

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Цус сэлбэлт судлалын үндэсний төв



**ББ-ДУ-1-04-07**

**НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ  
ГАРЫН АВЛАГА**

<b>НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ГАРЫН АВЛАГА</b> ББ-ДУ-1-04-07	Мөрдөж эхэлсэн огноо	2017.04.17-25
	Өөрчлөлт оруулсан огноо	2023.10.12
	Өөрчлөлтийн дугаар	6

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Боловсруулсан:	Хянан шинэчилсэн:
Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга Т.Алимаа	Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга А.Амарзаяа
2017.04.20	2023.06.11-10.11
Гарын үсэг:	Гарын үсэг:

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Өөрчлөлт оруулсан бүртгэл

Д/д	Хуудасны дугаар	Зүйл	Өөрчилсөн огноо	Оруулсан өөрчлөлт	Шалтгаан	Өөрчлөлт оруулсан албан тушаалтан
1	8	1.6	2018 оны 05 сар 05	Төвийн Магадлан итгэмжлэлийн дугаар хугацааг засаж оруулав	Магадлан итгэмжлэлийн гэрчилгээний дугаар, хүчинтэй хугацаа сунгагдсан	Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга Т.Алимаа
2	10	1.7	2018 оны 05 сар 05	Төвийн 2017 онцлох үйл явдал	Төийн хамт олны 2017 оны 10 гол ололт амжилтыг нэмж оруулав.	
3	11	4	2018 оны 05 сар	ЭМ-ийн сайдын 2018 онд гарсан тушаалууд	Төвийн үйл ажиллагаанд мөрдөх хоблогдох тушаалуудыг шинэчилсэн.	
4	27	4.6	2018 оны 05 сар	ҮЯТ–ууд шинэчлэгдэн дугаар өөрчлөлт орсон шинээр нэмэгдсэн	Үйл явцын тодорхойлолт нэмэлт шинэчлэл хийсэн	
5	37	4,4,1	2018 оны 05 сар	Төвийн бүтэц үйл ажил лагааны стандарт шинэчлэгдсэн.	Төвийн үйл ажиллагааг, нарийн тодорхойлсон	
6	41	5.1.2	2019 оны 2 сар	Гадаад дотоод үйлчүүлэгчээс тогтмол санал хүсэлт авч үйл ажиллагаагаа сайжруулах	Үйлчүүлэгчийн санал хүсэлтийг алба тасгууд чиглэл, чиглэлээр авч хэвших	
7	5	1	2019 оны 2 сар	Хамрах хүрээнд 2 суурин төв, цус	ОУ-ын баталгаажуулалтын	

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

				цуглуулах хэсгийг нэмж оруулав.	байгууллагын аудиторын зөвлөмжийн дагуу	
8	6	1.1	2019 оны 2 сар	Төвийн тусгай зөвшөөрлийн хугацааг засч шинэчлэв.	Төвийн тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан.	Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга Т.Алимаа
9	11	1.7	2019 оны 2 сар	2018 оны онцлох үйл ажиллагааг нэмж оруулав	2018 оны жилийн тайлан нэгтгэгдэн гарсан тул	
10	31	4.4.1	2019 оны 3 сар	Боломж дээр нэмэлт шинэчлэл хийв	Төвийн нөхцөл байдлын үнэлгээний дүн шинэчлэгдсэн	
11	32	4.4.1	2019 оны 3 сар	Эрсдэл дээр нэмэлт шинэчлэл хийв	Төвийн нөхцөл байдлын үнэлгээний дүн шинэчлэгдсэн	
12	38	6.1.1	2019 оны 3 сар	Төвийн гадаад эрсдэл, сэргийлэх арга замыг нэмж оруулав	Төвийн нөхцөл байдлын үнэлгээний дүн шинэчлэгдсэн	
13	41	6.2.1	2019 оны 3 сар	Төвийн чанарын зорилтыг тодорхойлох, шалгуур үзүүлэлтийн тоо мэдээллийг ямар давтамжаар, хаанаас хэрхэн цуглуулж, үнэн зөвийг нотлох үүргийг тодруулж нэмэв.	ОУ-ын баталгаажуулалтын байгууллагын аудиторын зөвлөмжийн дагуу	
14	46	7.1.2	2019 оны 3 сар	Төвийн хүний нөөцийг хөгжүүлэх, мэдлэг ур чадвар олгох, хадгалах, өвлүүлэх	ОУ-ын баталгаажуулалтын байгууллагын аудиторын	

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

				чиглэлийг нэмж тусгалаа.	зөвлөмжийн дагуу	
15	50	7.1.4	2019 оны 4 сар	Үйл ажиллагаа хэрэгжүүлэх орчинд холобогх стандарт, журмуудыг иш татан орууллаа.	ОУ-ын аудиторын зөвлөмж	Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга Т.Алимаа
16	53	7.1.6	2019 оны 4 сар	Төвийн мэдлэгийг хадгалах, хөгжүүлэх ХН-ийн залгамж холбоо хөгжүүлэх нэмэлт оруулав.	ОУ-ын аудиторын зөвлөмж	
17	59	7.5.3.2	2019 оны 4 сар	Баримт бичиг цахимд байршуулж, ашиглах талаар нэмэлт орууллаа.	ОУ-ын аудиторын зөвлөмж	
18	70-71	8.5.3	2019 оны 4 сар	Цусны донорын эрүүл мэндийг хянах нотолгоо гаргах, баримтжуулах үйл ажиллагааг нэмж тусгалаа.	ОУ-ын баталгаажуулалтын байгууллагын аудиторын зөвлөмжийн дагуу	
19	72	8.5.5	2019 оны 4 сар	Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн дараа хийх хяналт, эмнэлгийн байгуулагуудад өгөх зөвлөмж, мөрдөх журмыг нэмж оруулав.	ОУ-ын аудиторын зөвлөмж	
20	72	8.5.6	2019 оны 04 сар	Төвийн үйл явц, ажиллагаанд өөрчлөлт, хяналт хийх зөвшөөрөл олгох нотолгоог нэмж тодруулга орууллаа.	ОУ-ын баталгаажуулалтын байгууллагын аудиторын зөвлөмжийн дагуу	

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

21	73	8.6.в	2019 оны 04 сар	ЦЦБ олгох зөвшөөрлийг ТТ эрхлэгч, эмч нар олгох нэмэлт хийв	ОУ-ын аудиторын зөвлөмж	ЦЧАБА-ны дарга Т.Алимаа
22	7	1.1	2020 оны 02 сар	Хамрах хүрээнд ХЭМАБ-ыг нэмж оруулав	ISO9001, ISO45001 стандартын шаардлагыг нэгтгэх	
23	9	1.2	2020 оны 09 сар	ЦССҮТ тодорхойлолт өөрчлөлт оров	ЭМ-ийн сайдын 2020 оны А/445 тушаал	
24	11	1.3	2020 оны 10 сар	Алсын хараа, Эрхэм зорилго жижиг өөрчлөлт	А/445 тушаал	
25	19	4.3	2020 оны 10 сар	ХЭМАБ-ын тогтолцоог нэмж өргөтгөв	45001:2018 стандарт	
26	27-28	4.4	2020 оны 10 сар	Дэмжих албаны үйл ажиллагаанд өөрчлөлт оров	А/445 тушаал	
27	37	1.8	2020 оны 10 сар	Хүний халдварт өвчин, цар тахал	Үүссэн нөхцөл байдал	
28	39	5.1	2020 оны 10 сар	ХЭМАБ-ын тогтолцоо	45001:2018 стандарт	
29	40	5.2	2020 оны 10 сар	ХЭМАБ-ын бодлого	45001:2018 стандарт	
30	44	6.2	2020 оны 10 сар	ХЭМАБ-ын зорилт	45001:2018 стандарт	
31	61		2020 оны 10 сар	ЦА-ны үйл ажиллагаанд мөрдөх тушаал өөрчлөлт	Эм-ийн сайдын 2020 оны 373 дугаар тушаал	
32	46-47	5.4	2021 оны 05 сар	Ажилчдын оролцоо, зөвлөлдөөн	45001:2018 стандартын шаардлага	

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

				хэсгийн нэмж оруулав.		
33	-	1.7	2023 оны 10 сар	Цусны албаны ололт амжилт 1993-2018 он	Төвийн 1993-2018 оны ололт амжилтуудыг хасав	ЦЧАБА-ны дарга А.Амарзаяа
34	15	4.1	2023 оны 10 сар	Байгууллагын гадаад, дотоод асуудлуудын эерэг, сөрөг нөлөөг нэмэв	Дэлгэрүүлэв	
35	20	4.2	2023 оны 10 сар	Гадаад, дотоод сонирхогч талуудын хэрэгцээ хүлээлт	Дэлгэрүүлэв	
36	22	4.3	2023 оны 10 сар	Нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээ шинэчлэв	Ерөнхий захирлын 2023 оны А/67 тушаал	
37	24	4.4	2023 оны 10 сар	НМТ-ы үйл явцыг зураглалаар оруулав	Зураглал оруулсан	
38	31	5.2	2023 оны 10 сар	Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого шинэчлэв	Ерөнхий захирлын 2023 оны А/67 тушаал	
39	35	6.1.1	2023 оны 10 сар	Эрсдлийн ангилал оруулав	Аудитын зөвлөмж	
40	39	6.2	2023 оны 10 сар	Нэгдсэн менежментийн тогтолцооны зорилт шинэчлэв	Ерөнхий захирлын 2023 оны А/67 тушаал	
41	40	6.3	2023 оны 10 сар	Өөрчлөлт хийх үйл явц	Зураглал оруулсан	
42	41	7.1.1	2023 оны 10 сар	Үйл явцад шаардагдах	Хүснэгт оруулсан	

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

				нөөцийг дэлгэрүүлсэн		
43	46	7.2	2023 оны 10 сар	Чадамж тодорхойлсон	Аудитын зөвлөмж	



## Бүлэг

### Өөрчлөлт оруулсан бүртгэл

#### Агуулга

1. Хамрах хүрээ
2. Норматив иш таталт
3. Нэр томъёо ба тодорхойлолт
4. Байгууллагын төлөв байдал
  - 4.1 Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох
  - 4.2 Сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг ойлгох
  - 4.3 Чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох
  - 4.4 Чанарын менежментийн тогтолцоо ба үйл явц / ажиллагаа  
Шаардагдах нөөц:  
Боломж  
Мэдээлэл хөтөлж, хадгалах.
5. Манлайлал
  - 5.1 Манлайлал ба амлалт
  - 5.2 Бодлого
  - 5.3 Зохион байгуулалтын үүрэг, хариуцлага, эрх мэдэл
6. Төлөвлөлт
  - 6.1 Эрсдэл болон боломжуудыг авч үзэх арга хэмжээ
  - 6.2 Чанарын зорилтууд ба төлөвлөлт
  - 6.3 Өөрчлөлтийг төлөвлөх
7. Тулгуур хүчин зүйл (Дэмжих үйл явц)
  - 7.1 Нөөц
  - 7.2 Ур чадвар – Чадамж
  - 7.3 Мэдлэг олголт
  - 7.4 Холбоо, харилцаа
  - 7.5 Баримтжуулсан мэдээлэл
8. Ажиллагаа
  - 8.1 Ажиллагааны төлөвлөлт ба хяналт
  - 8.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлага
  - 8.3 Бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн ба боловсруулалт хийх
  - 8.4 Гаднаас авч буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт
  - 8.5 Үйлдвэрлэл явуулах ба үйлчилгээ үзүүлэх
  - 8.6 Бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргаж, бэлтгэх
  - 8.7 Үл тохирол бүхий гаралтын хяналт
9. Гүйцэтгэлийн үнэлгээ
  - 9.1 Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ
  - 9.2 Дотоод аудит
  - 9.3 Удирдлагын дүн шинжилгээ
10. Сайжруулалт
  - 10.1 Ерөнхий зүйл
  - 10.2 Үл тохирол ба залруулах арга хэмжээ
  - 10.3 Байнгын сайжруулалт

ЧАНАРЫН БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ГАРЫН АВЛАГА

**ОРШИЛ**

**ЦССҮТ-ийн алсын хараа:**

“Цус сэлбэлт судлалын чиглэлээр Азидаа тэргүүлэгч орны жишигт хүрнэ.”

**Эрхэм зорилго:**

“Чадварлаг баг, дэвшилтэт технологи, инновацид тулгуурлан, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд оршино.”

**Үнэт зүйлс:**

- Мэргэшсэн, ёс зүйтэй, ур чадвартай хүний нөөц
- Тэгш хүртээмжтэй, чанартай, аюулгүй тусламж үйлчилгээ
- Удирдлагын манлайлал, хариуцлага, ил тод байдал, эрхэм зорилго
- Хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, техник, шинэ технологи, материаллаг нөөц

**ЦССҮТ-ийн товч түүх:**

БНМАУ-ын СнЗ-ийн 1956 оны 1-р сарын 20-ны 16 тоот тогтоолоор Улаанбаатар хотын мэс заслын больницын дэргэд эмнэлгийн байгууллагуудыг бэлтгэн хадгалсан эмчилгээний цусаар хангах “Цус сольж эмчлэх газар”, 1962 оны 9-р сарын 26-ны 505 тоот тогтоолоор “Цус сэлбэх төв станц”-ыг Улаанбаатар хотод байгуулах, улмаар бүх аймгуудад цусны салбар станцыг байгуулж, 1963 онд Цус сэлбэх төв станцын анхны захирлаар их эмч Ч.Шаравыг, зөвлөхөөр ЗХУ-ын мэргэжилтэн И.Ф.Хоменко нарыг томилсноор Монгол улсад цус сэлбэх алба бие даан албан ёсоор байгуулагдсан билээ.

1971 онд Цусны сэлбэх төв станцын орон тоо, бүтцийг шинэчлэн өргөжүүлж БНЧУ-ын буцалтгүй тусламжаар өдөрт 60 донорт үйлчлэх хүчин чадал бүхий, иж бүрэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон цусны төвийн зориулалтын шинэ байр ашиглалтанд орсон.

1973 онд БНМАУ-ын СнЗ-ийн 253 дугаар тогтоолоор хуучин нэрээр “Бактер шинжилгээний газар”-ыг Эрүүл ахуй халдвар нян судлалын улсын институтээс салган, Цус сэлбэх төв станцтай нэгтгэж Улсын эм хангамж, үйлдвэрийн газрын харъяа “Биобэлдмэл, цусны үйлдвэр шинжилгээний институт” болгон өөрчилсөн.

1987 онд СнЗ-ийн 11-р тогтоол, Эрүүлийг хамгаалах яамны сайдын А/07 тоот тушаалаар Биобэлдмэл, цусны үйлдвэр шинжилгээний институтын биобэлдмэлийн хэсгийг Эрүүл ахуй халдвар, нян судлалын институтэд шилжүүлж, Цус сэлбэх станцыг бие даалган “Биобэлдмэл, цусны үйлдвэр шинжилгээний институт”, 1990 онд СнЗ-ийн 161-р тогтоолыг үндэслэн Эрүүлийг хамгаалах яамны сайдын А154 тоот тушаалаар “Биобэлдмэл цусны үйлдвэр шинжилгээний институт”-ыг татан буулгаж “Цус сэлбэлт судлалын төв” нэртэйгээр ЭХЯ-ны харъяанд шилжүүлэв.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

2007 оны 5-р сарын 23-ны өдөр Эрүүл мэндийн сайдын А/138 тоот тушаалаар “Цус сэлбэлт судлалын төв”-ийг “Цус сэлбэлт судлалын үндэсний төв” болгон өргөжүүлж, ЦССҮТ-ийн бүтэц, үйл ажиллагааны дүрмийг баталсан бөгөөд ЭМС-ын 2013 оны А/408, 2016 оны А/137, 2020 оны А/445 тоот тушаалаар ЦССҮТ-ийн дүрэм, бүтэц тус тус шинэчлэгдэн батлагдсан.

ЭМСХХ-5 төслийн хүрээнд Монгол улсын ЗГ, АХБ-ны санхүүжилтээр ЦССҮТ-ийн шинэ байр 2016 онд ашиглалтанд орж техник, технологийн бүрэн шинэчлэлийг хийсэн.

**ЦССҮТ-ийн ерөнхий мэдээлэл:**

Эрүүл мэндийн яамны харьяа Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь Улаанбаатар хотод байрлан:

- Төвийн 1,2-р байр, Дүнжингарав цус цуглуулах суурин төв болон цус цуглуулах хөдөлгөөнт хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагаа;
- Төвийн 1 дүгээр байранд цус шинжлэх, цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, олгох, сургалт зөвлөгөө болон эдгээрийг дэмжих бүхий л үйл ажиллагаа;
- Төвийн 2 дугаар байранд гамшиг, онцгой байдлын үед шинжилгээ хийх, цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шаардлагатай хэрэгслийн нөөц агуулах, “Гамшгийн нөөцийн төв”-ийг байгуулан ажиллаж байна.

**Албан ёсны хаяг:**

*Төвийн 1 дүгээр байр:* Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө – 49, Шуудангийн хаяг: 13395 ш/х-96, Улаанбаатар-49

*Төвийн 2 дугаар байр:* Сүхбаатар дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө – 13

*Дүнжингарав цус цуглуулах төв:* Баянзүрх дүүрэг, 26 хороо, Дүнжингарав худалдааны төвийн G хэсэг

**Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:** 9070001138

**Байгууллагын регистрийн дугаар:** 9128905

**Тусгай зөвшөөрлийн дугаар:** ЭҮ-02/23/3022 (2024 оны 1 сарын 10 хүртэл хүчинтэй)

**Тусгай зөвшөөрлийн чиглэл:** Цус, сийвэн цуглуулах, шинжлэх, иммунологийн лавлах лаборатори, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, эмнэлэгт олгох

**Үйл ажиллагаа:**

- Хүн амын дунд сайн дурын, авлагагүй цусны донорын үйлсийг сурталчлах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг Монголын улаан загалмай нийгэмлэг болон бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран зохион байгуулах, донороос цус, сийвэн, эс авах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, эмнэлэгт олгох
- Хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

- тушаал, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, гүйцэтгэлийг хянах
- Чиг үүрэг, эрхэм зорилго, салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангах
  - Цус сэлбэлт судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн лавлагаа шатны тусламж үзүүлэх
  - Цусны донорын бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох мэдээ тайлан, цусны донор алдаршуулах, урамшуулахтай холбоотой баримтыг цаасан болон цахим хэлбэрээр архивлах
  - Цус, цусан бүтээгдэхүүн, сорьцыг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах
  - Улсын нөөцийн тухай хуулиар хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэх
  - Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байраар хангах, тэдний мэргэжил, мэдлэг, ур чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах
  - Ажилтан, үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх
  - Хууль тогтоомжоор олгогдсон бусад үүрэг

### **НЭГ. ХАМРАХ ХҮРЭЭ:**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн чанарын болон хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны (Цаашид Нэгдсэн менежментийн тогтолцоо гэх) гарын авлага нь ЦССҮТ-ийн нийт ажилтанд зориулсан гарын авлага, лавлах бөгөөд энэхүү баримт бичгийг ЦССҮТ-ийн бусад бодлогын баримт бичиг, бүртгэлтэй хамт уншихад тохиромжтой.

Нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээнд “Цус цуглуулах, шинжлэх, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, олгох, сургалт, зөвлөгөө болон эдгээрийг дэмжих бүхий л үйл ажиллагаа”-г хамруулна.

Энэхүү гарын авлага нь ЦССҮТ-ийн нэгдсэн менежментийн тогтолцооны шаардлагыг тодорхойлж, бүтээгдэхүүн үйлчилгээг цусны донор, үйлчлүүлэгч, цус цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эмнэлгүүдийн эмч, мэргэжилтэн, эмчлүүлэгчдэд хүргэхдээ тэдний хэрэгцээ, хүлээлтийг хангах чадвартайг харуулна. Үүнд:

- Цусны донорыг элсүүлэх, сонгох, бүртгэх, цус, сийвэн, эс цуглуулах үйл ажиллагаанд цусны донорын сэтгэл ханамжийг хангаж, эрсдэл багатай донороос цус цуглуулах
- Лавлагаа болон иммуногематологийн шинжилгээний чанарын баталгааг хангах
- Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, эмнэлгийн захиалгын дагуу нийлүүлэх үйл ажиллагааг тогтвортой, аюулгүй, чанартай үзүүлэх
- Эмч, мэргэжилтэн, ажиллагсад, үйлчлүүлэгчид, сонирхогч талуудын аюулгүй байдлыг хангах зорилгоо биелүүлэх боломж олгоно.

### **ХОЁР. НОРМАТИВ ИШ ТАТАЛТ**

Дараах баримт бичгийг бүхэлд нь болон хэсэгчлэн норматив байдлаар эш татсан ба тэвгээрийг хэрэглэх зайлшгүй шаардлагатай. Хугацаа заасан ишлэлийн хувьд зөвхөн

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

тухайн хэвлэлийг ашиглана. Хугацаа заагаагүй ишлэлийн хувьд иш татсан баримт бичгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ.

Төвийн үйл ажиллагаанд Монгол улсын хууль 28, УИХ-ын тогтоол 3, Ерөнхийлөгчийн зарлиг 2, Засгийн газрын тогтоол 8, Олон улсын болон үндэсний стандарт 14, Эрүүл мэндийн сайдын тушаал 55, төвийн захирлаар батлуулсан Үйл явцын тодорхойлолт 9, ерөнхий журам 46, нэгдсэн лабораторийн журам 24, стандарт ажиллагааны заавар 81, тоног төхөөрөмжийн ажлын заавар 39, ажлын заавар 60, маягт бүртгэл 180, хяналтын хуудас 36-г мөрдөнө.

**Холбогдох баримтжуулсан мэдээлэл:**

- ЦССҮТ-ийн баримт бичгийн мастер лист

**ГУРАВ. НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ**

Энэхүү нэгдсэн менежментийн тогтолцооны гарын авлагад дараах нэр томьёо, тодорхойлолтуудыг хэрэглэнэ.

- 3.1 Менежментийн тогтолцоо:** Бодлого, зорилтууд, үйл явцыг бий болгох, тэдгээр зорилтод хүрэхтэй холбоотой байгууллага дахь хоорондоо харилцан хамаарч эсвэл харилцан үйлчлэлцэж байдаг хүчин зүйлсийн цогц
- 3.2 Чанарын гарын авлага:** Чанарын бодлогыг багтаасан байгууллагын чанарын менежментийн тогтолцоонд зориулсан үзүүлэлт
- 3.3 Чанар:** Багц үзүүлэлт нь шаардлагыг биелүүлэх хэр хэмжээ
- 3.4 Чанарын хяналт:** Чанарын шаардлагуудыг хангахад чиглэсэн чанарын менежментийн нэг хэсэг
- 3.5 Чанарын баталгаажуулалт:** Чанарын шаардлага хангагдана гэсэн итгэл бий болгоход чиглэсэн чанарын менежментийн нэг хэсэг.
- 3.6 Чанарын сайжруулалт:** Чанарын шаардлагуудыг хангах чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн чанарын менежментийн нэг хэсэг
- 3.7 Шаардлага:** нийтээр зөвшөөрсөн эсвэл гол төлөв мэдээжийн буюу албан журмын шинжтэй тогтоосон хэрэгцээ буюу хүлээлт
- 3.8 Чадамж:** Зорьсон үр дүнд хүрэхийн тулд мэдлэг ба ур чадварыг хэрэглэх чадвар
- 3.9 Үйл явц:** Төлөвлөсөн үр дүнд хүрэхийн тулд оролтыг гаралт болгон хувиргах харилцан уялдаа буюу харилцан үйлчлэл бүхий багц үйл ажиллагаа
- 3.10 Гаралт:** Үйл явцын гарц, үр дүн
- 3.11 Сонирхогч тал:** Байгууллагын шийдвэр болон үйл ажиллагаанд нөлөөлж чадах, тэдгээрийн нөлөөлөлд автах эсвэл автах боломжтой гэж үзэж буй хүн эсвэл байгууллага
- 3.12 Дээд удирдлага:** ЦССҮТ-ийн захирлын зөвлөл, эрдмийн зөвлөл, ЦССҮТ-ийн захирлыг ойлгоно.
- 3.13 Гадны нийлүүлэгч:** Байгууллагын үйл ажиллагаа, үйл явцын нэг хэсгийг гүйцэтгэж буй үндсэн орон тооны бус гадны хүн буюу байгууллага
- 3.14 Хүртээмж:** Чадамжийн өргөн хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээ, орчин, байгууламж, төхөөрөмжийг хүн /-д/ хэрэглэх, хэрэглэгдэх байдал

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

- 3.15 Хэрэглэгдэхүйц:** Тодорхой хэрэглэгч, үйлчлүүлэгч хэрэглээний тогтоосон төлөвт үр дүн, үр ашиг болон сэтгэл ханамжтай тогтоосон зорилгод хүрэхийн тулд хэрэглэж болох бүтээгдэхүүн, үйлчилгээ, орчин эсвэл байгууламжийн хэм хэмжээ
- 3.16 Баримтжуулсан мэдээлэл:** Байгууллагын хяналтанд байлгаж, мөрдөж хадгалвал зохих мэдээлэл ба түүний зөөгч
- 3.17 Аюултай тохиолдол:** Ажлаас, эсвэл уг ажлыг гүйцэтгэж байх явцад гэмтэл ба/эсвэл эрүүл мэндийн хохиролд хүргэж болох эсвэл хүргэсэн тохиолдлууд
- 3.18 Аюул:** Гэмтэл ба эсвэл эрүүл мэндийн хохиролд хүргэж болох эх үүсвэр
- 3.19 Эрсдэл:** Тодорхойгүй байдлын үр нөлөө буюу төлөвлөсөндөө хүрч чадахгүй нөхцөл байдал үүсэхийг ойлгоно.
- 3.20 ХЭМАБ-ын эрсдэл:** Ажилтай холбоотой аюултай үйл явдал эсвэл нөлөөлөл тохиолдох магадлал ба үйл явдал эсвэл нөлөөллийн улмаас учирч болох гэмтэл ба/эсвэл эрүүл мэндийн хохирлын хэр хэмжээний хослол
- 3.21 Боломж:** Эрсдэлээс гарах эерэг өөрчлөлт нь боломж бий болгох боловч эрсдлийн эерэг үр дүн бүр боломж авч ирдэггүй
- 3.22 ХЭМАБ-ын боломж:** ХЭМАБ-ын гүйцэтгэлийг сайжруулахад хүргэж болох нөхцөл байдал эсвэл багц нөхцөл байдал
- 3.23 ХЭМАБ-ын гүйцэтгэл:** Ажилтнуудыг гэмтэл ба эсвэл эрүүл мэндийн хохиролоос сэргийлэх ажлын үр нөлөөтэй байдал ба аюулгүй, эрүүл ажлын байруудаар хангахад хамараах гүйцэтгэл (хэмжиж болохуйц үр дүн)
- 3.24 Оролцоо:** Шийдвэр гаргах явц дахь оролцоо
- 3.25 Зөвлөлдөөн:** Шийдвэр гаргахаас өмнө санал бодлыг сонсох
- 3.26 Дүн шинжилгээ:** Тогтоосон зорилгод хүрэхэд хэр тохиромжтой, хангалттай бөгөөд үр нөлөөтэй болохыг тодорхойлохын тулд явуулах үйл ажиллагаа
- 3.27 Мониторинг:** Тогтолцоо, үйл явц эсвэл үйл ажиллагааны бодит байдлыг тодорхойлох
- 3.28 Аудит:** Аудитын нотолгоог олж, энэ нь аудитын шалгууртай ямар хэмжээнд нийцэж буйг бодитойгоор тогтоох, байнгын, бие даасан, баримтжуулсан үйл явц
- 3.29 Үр нөлөө:** Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хүрсэн байдлын хэмжээ
- 3.30 Залруулах арга хэмжээ:** Гарсан алдаа буюу нэгэнт илэрсэн үл тохирлыг дахин гаргахгүйн тулд түүний учир шалтгааныг арилгахын тулд хэрэгжүүлэх арга хэмжээ
- 3.31 Тасралтгүй сайжруулалт:** Гүйцэтгэлийг сайжруулах давтагдах үйл ажиллагаа. Сайжруулалт нь залруулга, залруулах арга хэмжээ, тасралтгүй сайжруулалт, огцом өөрчлөлт, инновац, өөрчлөн байгуулалтыг багтааж болно.
- 3.32 Үл тохирол:**

**Товчилсон үгсийн тайлбар:**

ЦССҮТ	Цус сэлбэлт судлалын үндэсний төв
ЦСТ	Цусны салбар төв
ЦЧАБА	Цусны чанар, аюулгүй байдлын алба
ЗМА	Захиргаа, маркетингийн баг
ЭШМТА	Эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн алба
СБА	Санхүү бүртгэлийн алба
СҮА	Сувилахуй үйлчилгээний алба
ДЗБТ	Донор зохион байгуулалтын тасаг

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

ҮТ	Үйлдвэрлэлийн тасаг
НЛТ	Нэгдсэн лабораторийн тасаг
ИТТ	Инженер, техникийн тасаг
САЗ	Стандарт ажиллагааны заавар
АЗ	Ажлын заавар
ТТАЗ	Тоног төхөөрөмжийн ажлын заавар
ХСХ	Халдварын сэргийлэлт хяналт
ЦЦБ	Цус цусан бүтээгдэхүүн
ХЭМАБ	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал

### ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

#### 4.1 Байгууллага ба түүний төлөв байдлыг ойлгох нь

**Байгууллага нэгдсэн менежментийн тогтолцооны хүрээнд зорьсон үр дүнд хүрэх, зорилтоо хэрэгжүүлэх боломж, стратеги чиглэлд хамааралтай гадаад, дотоод асуудлыг тодорхойлсон байна. байгууллага нь эдгээр гадаад болон дотоод асуудлуудад хамаарах мэдээлэлд мониторинг, дүн шинжилгээ хийдэг байна.**

4.1.1 ЦССҮТ нь нэгдсэн менежментийн тогтолцооны хүрээнд зорьсон үр дүнд хүрэх (эрхэм зорилго, алсын хараа), зорилтоо хэрэгжүүлэх (стратеги төлөвлөгөө) боломжид хамааралтай гадаад, дотоод орчны асуудлыг тодорхойлохдоо дараах хүчин зүйлсийг авч үзнэ. Үүнд:

Гадаад асуудал	Эерэг нөлөө (Боломж)	Сөрөг нөлөө (Эрсдэл)
Эдийн засгийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> <li>АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр ЭМСХХ-5 төсөл хэрэгжсэн барилга, эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж тавилга, технологийн иж бүрэн шинэчлэгдсэн.</li> <li>МУЗН-ийн донорын хөтөлбөрт донорын сургалт, сурталчилгаанд зарцуулах зардлын тодорхой хувийг ЭМ-ийг дэмжих сангаас санхүүжилт авах боломжтой.</li> <li>ЦЦБ-ний үнэ нэмэгдсэн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Улс орны эдийн засгийн чадавч сул төсвийн санхүүжилт хязгаарлагдмал, нэмэгддэггүй.</li> <li>Эм эмнэлгийн хэрэгсэл, уут хүүдий оношлуурын үнэ өндөр, инфляцийн өсөлттэй холбоотой үнэ хэлбэлзэх</li> <li>МУЗН-д донорын сургалт сурталчилгаа явуулах санхүүжилт маш бага</li> <li>Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалин, урамшууллын хэмжээ бага</li> </ul>
Техник, технологийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> <li>Олон нийтийн дунд цахим мэдээллийн сүлжээний хэрэглээ нэмэгдэж байгаа.</li> <li>Сошиал хэлбэрийг ашиглан зардал багатай сургалт сурталчилгаа явуулах боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төсвөөс шалтгаалан нэвтрүүлсэн шинэ технологитой уялдсан хүрэлцээтэй зардал, санхүүжилт шийдвэрлэгдэхгүй.</li> </ul>

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

	<ul style="list-style-type: none"> <li>Мэдээ мэдээллийг улсын хэмжээнд түргэн шуурхай солилцох боломж бүрдэж байна.</li> </ul>	
Улс төрийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> <li>Монгол улсын Цусны албыг хөгжүүлэхэд анхаарч төрийн бодлогоор дэмжиж ирсэн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Улс төрийн тогтворгүй байдлаас шалтгаалан хүний нөөцийн тогтвор суурьшил алдагдах</li> <li>ЭМЯ-ны бүтэц, хүний нөөц өөрчлөгддөг</li> </ul>
Хууль, эрх зүйн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> <li>Донорын тухай хууль</li> <li>Улсын нөөцийн тухай хууль</li> <li>Эрүүл мэндийн сайдын тушаалаар үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журам батлагдаж үйл ажиллагаа явуулах эрх зүйн таатай орчин бүрдсэн</li> <li>Цусны аюулгүй байдлын талаар баримтлах ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлдэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ЭМЯ-ны тушаал шийдвэр уян хатан биш удаан өөрчлөгддөг</li> </ul>
Нийгмийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> <li>Хүн амын дунд эрүүл амьдрах хэв маяг, зөв хооллолтын талаар мэдлэг, хандлага сайжирч байгаа</li> <li>Сайн үйлсэд нэгдэх, тэмдэглэлт өдрүүдэд ач холбогдол өгөх зэрэг зөв хандлага нэмэгдэж байгаа нь донорын эгнээг өргөжүүлэх, донор сонголтонд сайнаар нөлөөлөх боломжтой.</li> <li>Аж ахуй нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагаа ухамсарлах, энэ хүрээнд үйл ажиллагааны дэмжлэг үзүүлдэг болсон.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Цус сэлбэлтийн талаарх уламжлалт сэтгэлгээний өөрчлөлт удаан</li> <li>Халдварт болон халдварт бус өвчлөлийн тоо нэмэгдсээр байна</li> <li>Цус өгөх болон ЦЦБ-ний хэрэглээний талаар хүн амын дунд буруу мэдлэг, мэдээлэл тархсан</li> <li>Цусаар дамжих халдварын тохиолдлын тоо нэмэгдэж байгаа</li> <li>Монгол орны байгаль цаг агаарын нөхцлийн нөлөөлөл</li> </ul>
Зах зээлийн хүчин зүйлс (хэрэглэгч, түншлэгч)	<ul style="list-style-type: none"> <li>Донорын тоо, ЦЦБ хэрэглэх эмнэлгүүдийн тоо жил бүр нэмэгдэж байна.</li> <li>Донор зохион байгуулагч байгууллага болон хандивлагч, хамтран ажиллагч байгууллагын тоо өсөн нэмэгдэж байгаа.</li> <li>Лавлагаа шинжилгээ хийлгэх үйлчлүүлэгч болон хамтран ажилладаг байгууллагын тоо нэмэгдэх боломжтой.</li> <li>Эрүүл мэндийн салбарт хэрэгжих дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүд нэмэгдэж байна.</li> <li>Багц цагийн сургалтад хамрагдагсдын тоо нэмэгдэж байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн болон аж ахуй нэгж байгууллага, салбар дундын хамтын ажиллагаа сайн хөгжөөгүй</li> <li>Хүн амын дунд цусны донор болон, ЦЦБ-ний хэрэглээний талаар мэдлэг, мэдээлэл бага</li> <li>Хүн амын эрүүл мэндийн боловсрол хангалтгүй</li> <li>Эмнэлгийн цусны нөөцийн эмч, сувилагч, эмч нарын зохистой хэрэглээний мэдлэг хангалтгүйгээс зохистой хэрэглээ хэвшээгүй.</li> <li>Өвчлөлийн бүтэц өөрчлөгдсөн, дотооддоо эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын тоо нэмэгдэж байгаа зэрэгтэй холбоотой ЦЦБ-ний хэрэглээ өсч байна.</li> </ul>



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Дотоод асуудал	Эерэг нөлөө (Боломж)	Сөрөг нөлөө (Эрсдэл)
Байгууллагын бүтэц, ажил үүрэг ба хариуцлага	<ul style="list-style-type: none"> <li>Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай мэргэжлийн өрсөлдөгчгүй төв</li> <li>Газар хөдлөлтөнд тэсвэртэй зориулалтын шинэ байр ашиглалтанд орсон</li> <li>Техник, тоног төхөөрөмжийн хангамж сайн, шинэ</li> <li>ЦЦБ-ний шинжилгээ, үйлдвэрлэлийн шинэ технологүүд нэвтрүүлсэн</li> <li>Гамшгийн үеийн бэлэн байдлын нөөц төв байгуулагдсан</li> <li>Маркетингийн нэгжтэй</li> <li>Лабораторийн MNS 15189:2015-ийг нэвтрүүлсэн.</li> <li>ISO 9001:2016 стандарт нэвтрүүлсэн</li> <li>ISO 45001:2018 стандарт нэвтрүүлсэн</li> <li>Цусны албанд баримтлах чанарын бодлоготой</li> <li>Цусны албанд удаан ажилласан туршлагатай ОУ-ын зөвлөхтэй хамтран ажилласан.</li> <li>2020 онд бүтэц, үйл ажиллагааны дүрмийг шинэчилсэн.</li> <li>ЦССҮТ-ийн үйл ажиллагааны батлагдсан стандарттай MNS 6647:2017</li> <li>Тусгай мэргэжлийн төвүүдээс анх удаа магадлан итгэмжлэгдэж, 3 удаа хугацааг сунгуулсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Цусны сонор сэрэмжийн тогтолцоо бүрэн хэвшээгүй.</li> <li>Байгалийн гамшиг, гоц аюулт халдварт өвчний үед донорын нөөц бага</li> <li>Байгууллагын соёлын хүчин зүйл тодорхойлогдоогүй</li> </ul>
Бодлого зорилтууд ба стратеги	<ul style="list-style-type: none"> <li>Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, хөгжлийн стратегийг тодорхойлсон</li> <li>Эрхэм зорилго нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, батлагдсан бодлого хөтөлбөртэй уялдсан, үйл ажиллагаагаа олон улсын жишигт хүргэхийг эрмэлзсэн.</li> <li>Алсын хараа, үнэт зүйлсээ тодорхойлсон.</li> <li>Байгууллагын зорилт, стратегийг тодорхойлоход хамт олны оролцоог бүрэн хангаж, сургалт зохион байгуулж хэлэлцүүлсэн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрхэм зорилго алсын харааг хэрэгжүүлэх, цус сэлбэлтийн чиглэлээр азидаа тэргүүлэгч орнуудын жишигт хүрэхэд энэ чиглэлээр хийгдсэн судалгаа шинжилгээний ажил бага, хийх санхүүгийн боломж хязгаарлагдмал</li> <li>Алсын харааг хэрэгжүүлэхэд хугацаа их шаардагдах</li> </ul>

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

<p>Тоног төхөөрөмж, техник технологи</p>	<ul style="list-style-type: none"> <li>• ЦЦБ-ний үйлдвэрлэлд олон төрлийн шинэ технологи нэвтрүүлэн, 12 төрлийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн.</li> <li>• Үйл ажиллагаа бүртгэл, мэдээлэл, хяналтын цахим хэлбэрт бүрэн шилжсэн.</li> <li>• Удирдлага, засвар, хяналтын цахим систем нэвтрүүлсэн.</li> <li>• ДЭМБ-аас зөвлөмж болгож байгаа бүх шинжилгээг хийх боломж бүрдсэн.</li> <li>• Сошиал медиаг байгууллагын болон донорын сургалт сурталчилгаанд ашиглаж байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Шинэ технологийг хэрэгжүүлэх материал дагалдах хэрэгслийн өртөг өндөр.</li> <li>• Цуглуулсан тоо мэдээлэлд ач холбогдол бүхий бүрэн дүн шинжилгээ хийдэггүй.</li> <li>• Аймаг орон нутагт тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ сул хөгжсөн.</li> </ul>
<p>Байгууллагын боловсруулсан стандарт, удирдамж, загварууд</p>	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМС-ын тушаалаар цусны аюулгүй байдлыг хангахтай холбоотой удирдамж, заавар, аргачлалууд батлагдсан.</li> <li>• ЭМС-ын тушаалаар батлагдсан Зонхилон тохиолдох өвчний үед ЦЦБ-ийг сэлбэх батлагдсан удирдамж заавартай.</li> <li>• Сургалт явуулах эрх зүйн орчин бүрдсэн (зөвшөөрөлтэй)</li> <li>• Төвийн дотоод журам, хамтын гэрээг шинэчлэн баталсан.</li> <li>• Дотоод үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ тогтмол хийгддэг.</li> <li>• Бүх үйл ажиллагааг батлагдсан заавар, стандартын дагуу хэрэгжүүлж баримтжуулалт хийдэг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажилчдын нийгмийн асуудлыг хамтын гэрээ, дотоод журамд тусгасан боловч хангалттай түвшинд шийдвэрлэгдэхгүй байна.</li> </ul>
<p>Ажлын нөхцлүүд</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх боломжтой.</li> <li>• Ажиллах орчин нөхцөл, өрөө тасалгааны хүртээмж сайн.</li> <li>• Нормын хувцас хамгаалах хэрэгслийн хангамж сайн.</li> <li>• Аюулгүй, тав тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн.</li> <li>• Уян хатан ажлын цагийн хуваарьтай.</li> </ul>	
<p>Хүний хүчин зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Цусны албанд шаардлагатай нарийн мэргэжлийн чиглэлээр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөцийн хангамж жил бүр нэмэгдэж байгаа ч хүрэлцээтэй</li> </ul>

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

<p>(ажилтны чадамж, байгууллагын соёл ба зан үйл)</p>	<p>Хөгжилтэй орнуудад мэргэжилтнүүд бэлтгэгдэж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Маркетинг, донорын сургалт сурталчилгаа хариуцсан 2 орон тоотой.</li> <li>• Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хариуцсан 2 инженертэй.</li> <li>• Цусны албанд удаан жил ажилласан туршлагатай донор зохион байгуулалт, лабораторийн болон технологич эмчтэй.</li> <li>• Эмнэлгийн мэргэжилтнүүдийн 94,5% нь нарийн мэргэшсэн.</li> </ul>	<p>хэмжээнд хүрээгүй, ажилчдын шилжилт хөдөлгөөн их.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Цусны албаны нарийн мэргэжлийн чиглэлээр эх орондоо мэргэжилтэн бэлтгэх боломжгүй</li> <li>• Санхүүгийн бэрхшээлээс шалтгаалан хангалттай тоогоор эмч, мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй оронд сургаж чаддаггүй.</li> <li>• Эмч мэргэжилтнүүдийн гадаад хэлний чадвар сул</li> <li>• Цусны албаны нарийн мэргэжлийн эмч нарыг орлох, сэлгэх бэлтгэгдсэн эмч дутагдалтай</li> <li>• Иммуногематологийн болон эмнэлзүйн трансфузиологийн өндөр хөгжилтэй оронд мэргэжилтэн бэлтгэх шаардлагатай</li> <li>• Нэвтрүүлсэн шинэ технологийн засвар үйлчилгээ техникийн сургалтанд мэргэжилтнүүдийг хамруулах боломж муу</li> </ul>
<p>Санхүү, төсөв</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Үндсэн болон нэмэлт үйл ажиллагааны орлого бүрдүүлдэг</li> <li>• Төлөвлөгөөнөөс илүү төвлөрүүлсэн орлогыг ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэхэд зарцуулах эрх зүйн орчин бүрдсэн</li> <li>• ЦЦБ-ний үнэ шинэчлэн батлагдсан</li> <li>• Жил бүр үйл ажиллагааны орлого нэмэгдэж байгаа</li> <li>• Төсөл хөтөлбөр болон хамтрагч байгууллагуудаас санхүү шийдвэрлүүлэх боломжтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Шинэ технологи нутагшуулах хүрэлцээтэй санхүүжилт шийдвэрлэгддэггүй, улс орны эдийн засгийн байдалтай холбоотой танагддаг, нэмэгддэггүй</li> <li>• Санхүү, төсвийн дутагдалтай байдлаас хүний нөөцийг шаардлагатай чиглэлээр ОУ-ын сургалт, семинарт хамруулж чаддаггүй</li> <li>• Үйл ажиллагааны орлоготой боловч зарцуулах боломж хомс</li> <li>• Жил бүр орлогын төлөвлөгөө нэмэгдэж батлагдаж байна.</li> </ul>

4.1.2 Дээрх гадаад, дотоод асуудалд хамаарах мэдээллүүдэд жил бүрийн 12 дугаар сард мониторинг, дүн шинжилгээ хийж, үнэлгээнд үндэслэн тухайн жилийн зорилтот түвшинд хүрч чадаагүй үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, алдаа дутагдлыг арилгах арга хэмжээг төлөвлөн, дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж ажилладаг.

ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:

- ЦССҮТ-ийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөө

#### 4.2 Сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагыг ойлгох

**Хэрэглэгчийн болон холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг байнга нийлүүлэхэд нөлөөлөх сонирхогч талууд болон эдгээрт хамаарах шаардлага, сонирхогч талуудад хамаарах мэдээлэл, холбогдох шаардлагад мониторинг, дүн шинжилгээ хийнэ. Мөн ХЭМАБ-ын шаардлагын аль нь хууль тогтоомжийн шаардлага ба бусад шаардлага болохыг тодорхойлно.**

4.2.1 ЦССҮТ нь шаардлага хангасан цус, цусан бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээг 24 цагийн турш байнга нийлүүлэх, үйлчилгээг хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын дагуу тасралтгүй үзүүлэх, тогтвортой амжилтанд хүрэхийн тулд өөрийн нэгдсэн менежментийн тогтолцоонд хамаарах сонирхогч талуудыг тодорхойлж, тэдний хууль тогтоомжид тусгагдсан хэрэгцээ ба хүлээлтийг заавал хангадаг.

4.2.2 Бусад хэрэгцээ ба хүлээлтийг хүлээн авах шийдвэр гаргах боломжтой бөгөөд нэгэнт хүлээн авсан бол үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах ба хэрэгжилтэд хяналт тавина.

Дотоод сонирхогч талууд	Хэрэгцээ ба хүлээлт
Ажилтан (үндсэн ба гэрээт)	<ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл, аюулгүй ажлын байраар хангагдах</li> <li>• Ажлаас шалтгаалсан осол гэмтлээс сэргийлэх</li> <li>• Хувийн хамгаалах хувцас, шаардлагатай хэрэгслийн хангамж</li> <li>• Мэдлэг, боловсрол, ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг</li> <li>• Ажлын байран дээрх эрүүл хөнгөлөлттэй үдийн хоол</li> <li>• Хөдөлмөрийн холбогдох хууль тогтоомжид нийцсэн гэрээ байгуулах</li> <li>• Амьжиргаанд хүрэлцээтэй цалин хөлсийг хугацаанд нь авах</li> <li>• Нийгмийн асуудлын дэмжлэг</li> </ul>
Дээд удирдлага	<ul style="list-style-type: none"> <li>• Чанартай, хүрэлцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ</li> <li>• Хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх</li> <li>• Орлогын өсөлт</li> <li>• Зардлын хэмнэлт</li> </ul>
ҮЭ-ийн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>• Гишүүд, иргэдийн хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах</li> <li>• ҮЭ-ийн гишүүний татвар авах</li> </ul>
Гадаад сонирхогч талууд	Хэрэгцээ ба хүлээлт
Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн	<ul style="list-style-type: none"> <li>• Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал</li> <li>• Холбогдох хууль, дүрэм, журам, зааврыг чанд мөрдөх, хэрэгжилтийг цаг хугацаанд нь тайлагнах</li> </ul>

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

төрийн захиргааны төв байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>Цусны аюулгүй байдалтай холбоотой бодлого хэрэгжилтийг мэргэжил арга зүйгээр хангах</li> <li>Цусны аюулгүй байдал болон хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой ноцтой тохиолдол гаргахгүй ажиллах</li> </ul>
Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>Цусны аюулгүй байдлыг хангах чиглэлээр гаргасан стратеги, зөвлөмж, санамж бичгийг хэрэгжүүлэх</li> </ul>
Эрүүл мэндийн хөгжлийн төв	<ul style="list-style-type: none"> <li>Статистик мэдээлэл цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн мэдээлэх</li> <li>Богино хугацааны болон мэргэшүүлэх сургалтыг заавар журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг мэдээлэх</li> </ul>
Монголын улаан загалмайн нийгэмлэг	<ul style="list-style-type: none"> <li>Донорын тухай хууль, МУЗН-ийн эрхзүйн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх хүрэлцээтэй санхүүжилт</li> <li>Хамтын дэмжлэгт ажиллагаа</li> </ul>
Цусны донорууд	<ul style="list-style-type: none"> <li>Үйлчилгээний цэвэр, тухтай, аюулгүй орчин</li> <li>Хурдан, чадварлаг үйлчилгээ</li> <li>Хүрэхэд ойр олон цэгийн үйлчилгээ</li> <li>Эелдэг харилцаа хандлага, зөв боловсон шуурхай үйлчилгээ, зөвлөгөө</li> <li>Цусны донорын алдаршуулалт, урамшуулалтад хамрагдах</li> <li>Донорт чиглэсэн сургалт, мэдээлэл хүлээн авах</li> <li>Эрүүл мэндээ хянах, эмчийн үзлэг, зөвлөгөөнд хамрагдах</li> </ul>
Лавлагаа шинжилгээ хийлгэх үйлчлүүлэгчид	<ul style="list-style-type: none"> <li>Үйлчилгээний цэвэр, тухтай, аюулгүй орчин</li> <li>Шуурхай, нэг цэгийн үйлчилгээ</li> <li>Шинжилгээний зөв хариу, богино хугацаанд хариугаа авах</li> <li>Цахим үйлчилгээ, эелдэг харилцаа хандлага, зөв боловсон, шуурхай үйлчилгээ, зөвлөгөө</li> </ul>
Орон нутгийн ЦСТөвийн эмч ажиллагсад	<ul style="list-style-type: none"> <li>Цус сэлбэлт судлалын чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг авах</li> <li>Шаардлагатай зөвлөмжийг шуурхай авах</li> </ul>
Цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч гэрээт эмнэлгүүд	<ul style="list-style-type: none"> <li>Эмчилгээний үр дүнтэй, чанартай, хүрэлцээтэй цус цусан бүтээгдэхүүнийг 24 цагаар олгох үйлчилгээ</li> <li>Цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангах</li> <li>Шинэ технологи, нотолгоонд суурилсан, чанар стандартад нийцсэн цус, цусан бүтээгдэхүүн нийлүүлэх</li> <li>Мэргэжлийн чадамжтай эмч, ажилтнууд ажиллах</li> <li>Цус, цусан бүтээгдэхүүний үнэ өрсөлдөхүйц байх</li> <li>Цусны аюулгүй байдал, зохистой хэрэглээний сургалтад хамрагдах</li> </ul>

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Баталгаажуулалтын байгууллага	<ul style="list-style-type: none"><li>• Олон улсын болон үндэсний стандартын шаардлагад нийцдэг байх</li><li>• Тасралтгүй сайжруулалт хийдэг байх</li></ul>
Ханган нийлүүлэгч байгууллага	<ul style="list-style-type: none"><li>• Урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах</li><li>• Захиалгын тоо, нэр төрлийн мэдээлэл тодорхой байх</li><li>• Урьдчилгаа төлбөр болон үлдэгдэл тооцоог хугацаандаа хийх</li></ul>
Анагаах ухааны боловсрол олгодог их дээд сургуулиуд	<ul style="list-style-type: none"><li>• Оюутан, эмч, мэргэжилтэнд сургалт зохион байгуулах</li><li>• Дадлага хийх нөхцөл бололцоогоор хангах</li><li>• Судалгаа, шинжилгээний ажлыг хамтран зохион байгуулах</li><li>• Судалгаа хийх мэргэжил арга зүйгээр хангах</li></ul>
Татварын болон нийгмийн даатгалын байгууллага	<ul style="list-style-type: none"><li>• Татварын хуулийг мөрдөх</li><li>• Тайланг алдаагүй, хуулийн хугацаанд нь тайлагнах</li><li>• Татвар, шимтгэлээ цаг тухайд нь төлөх</li></ul>
Харьяалагдах дүүргийн Онцгой байдлын хэлтэс	<ul style="list-style-type: none"><li>• Ажлын байрны галын аюулгүй байдлыг хангасан байх</li><li>• Гамшгийн үеийн хууль тогтоомж, төрийн бодлогыг биелүүлэх</li></ul>

Бид сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлага, хүлээлтийг хангагдаж буй талаарх мэдээллийг дараах аргуудаар цуглуулна. Үүнд:

- Хууль тогтоомжийн нийцэлд хийсэн дүн шинжилгээний тайлангийн биелэлтийн хувь
- Байнгын донорын эзлэх хувь
- Сэтгэл ханамжийн судалгааны дүн
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь
- Үл тохирлын бүртгэл, залруулалтын хувь
- Эмнэлэгт олгосон цус цусан бүтээгдэхүүний хангалтын хувь

**ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:**

- Өргөдөл, гомдлын тайлан
- Сэтгэл ханамжийн судалгааны тайлан
- Гэрээ ба гүйцэтгэлийн үзүүлэлтүүд
- Уулзалт, ярилцлагын тэмдэглэл
- Цус цуглуулалт болон цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

**4.3 Нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээ**

**Байгууллага нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээг тогтоохын тулд үг тогтолцоог хэрэглэх бололцоо ба зааг хязгаарыг тодорхойлно. Хамрах хүрээг тодорхойлохдоо байгууллага:**

**а/ 4.1-д заасан гадаад болон дотоод асуудлууд;**

**б/ 4.2-д заасан шаардлага:**

**с/ байгууллагын нийлүүлж буй бүтээгдэхүүн ба үйлчилгээ болон түүнтэй холбоотой төлөвлөсөн ба хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаануудыг тус тус харгалзан үзнэ.**

**Хамрах хүрээ нь баримтжуулсан мэдээлэл байдлаар хүртээмжтэй байна.**

4.3.1 Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь дараах үйл явцад нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлж байна. Үүнд:

- Цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулах үйл ажиллагаа;
- Донорын цусанд шинжилгээ хийх үйл ажиллагаа;
- Цуглуулсан цус, цусны бүрэлдэхүүн хэсэгт шинжилгээ хийх үйл ажиллагаа;
- Үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүнд шинжилгээ хийх үйл ажиллагаа;
- Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, олгох үйл ажиллагаа;
- Иммуногематологийн лавлагаа шинжилгээ хийх үйл ажиллагаа;
- Бусад бүх дэмжих үйл ажиллагаа нь нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээнд багтах ба MNS ISO 9001:2016, ISO 45001:2018 стандартын бүх шаардлагыг мөрдөнө.

4.3.2 Чанарын болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцоонд ЦССҮТ-ийн зохион байгуулалтын бүтцийн дагуу дараах алба, тасаг хамрагдана. Үүнд:

- Захиргаа, маркетингийн алба
- Цусны чанар, аюулгүй байдлын алба
- Санхүү, бүртгэлийн алба
- Эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн алба
- Сувилахуй, үйлчилгээний алба
- Донор зохион байгуулалтын тасаг
- Нэгдсэн лабораторийн тасаг
- Үйлдвэрлэлийн тасаг
- Инженер техникийн тасаг



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

4.3.3 Төвийн нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээг төвийн Ерөнхий захирал батлан, нийт ажиллагсад цахим болон мэдээллийн самбараар ил тод мэдээлсэн.

Хамрах хүрээнд багтаж буй нэгжүүдийн байршлын мэдээлэл:

№	Хамрах нэгжүүд	Байршил
1	Төвийн 1-р байр	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-49, УХТЭ-ийн зүүн хойд талд
2	Төвийн 2-р байр	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө-13, УНТЭ-ийн залгаа
3	Дүнжингарав цус цуглуулах төв	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Дүнжингарав нэг цэгийн үйлчилгээний төв G хэсэг

#### 4.4 Нэгдсэн менежментийн тогтолцоо ба үйл явц

**Байгууллага нь энэхүү олон улсын стандартын шаардлагад нийцсэн үйл явцууд болон тэдгээрийн харилцан үйлчлэл бүхий нэгдсэн менежментийн тогтолцоог бий болгож, хэрэгжүүлж, хадгалж, тасралтгүй сайжруулна.**

4.4.1 ЦССҮТ нь нэгдсэн менежментийн тогтолцоонд шаардагдах үндсэн болон дэмжих үйл явцуудыг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлнэ. Үүнд:

a/ үйл явцуудын шаардлагатай орц болон хүлээгдэж буй гарцыг үйл явцын зураглалд тодорхойлно.

b/ алба, тасаг бүр үйл явцуудын дэс дараалал, харилцан үйлчлэлийг тодорхойлсон байна.

c/ үйл явцуудыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх болон үйл явцуудад хяналт тавихдаа 8.5.1 болон 9.1, 9.2-т заасны дагуу хяналт, хэмжилт, гүйцэтгэлийн үзүүлэлтийн шалгуур, аргачлал, зааврыг тодорхойлж хэрэглэнэ.

d/ үйл явцуудад шаардлагатай нөөцийг 7.1-д заасны дагуу тодорхойлж, нөөцөөр хангах арга хэмжээ авна.

e/ үйл явцуудыг хэрэгжүүлэхдээ 5.3-т заасны дагуу үүрэг хариуцлага, эрх мэдлийг тогтооно.

f/ үйл явцуудыг хэрэгжүүлэхдээ 6.1-д заасны дагуу тодорхойлсон эрсдэл, боломжийг авч үзнэ.

g/ үйл явцуудыг 9 дүгээр бүлэгт заасны дагуу үнэлж, нэгдсэн менежментийн тогтолцооны зорилгод хүрэхэд шаардлагатай өөрчлөлтийг холбогдох баримт бичиг, журмын дагуу хийнэ.



h/ үйл явцууд болон нэгдсэн менежментийн тогтолцоог 10 дугаар бүлэгт заасны дагуу үйл ажиллагааны хүрээнд тасралтгүй сайжруулах арга хэмжээ авна.

4.4.2 ЦССҮТ нь өөрийн нэгдсэн менежментийн тогтолцоонд шаардагдах харилцан уялдаатай үйл явцуудыг тодорхойлж, хэрэгжүүлэн тасралтгүй сайжруулахын зэрэгцээ үйл явцыг баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр хадгалж, хэрэглэнэ. Доорх үйл явцууд нь хамтран ажиллаж байж сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тэдний сэтгэл ханамж болгон хувиргана.

**Менежментийн үйл явц:** ЦССҮТ нь цусны донор, гэрээт эрүүл мэндийн байгууллага, нийгэмд үнэ цэнтэй үйлчилгээг үзүүлэх, төвийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги зорилгод хүрэхийн тулд менежментийн арга хэрэгслийг ашиглах явдал юм. Энд үйл ажиллагааны чиглэл, зорилго, төлөвлөгөөг тодорхойлж, хүссэн үр дүнд хүрэхийн тулд удирдах, зохион байгуулах, хянах, үнэлэх, сайжруулах үйл явцууд байна.

**Үндсэн үйл явц:** Цусны донор, цус цусан бүтээгдэхүүн хэрэглэгч гэрээт эрүүл мэндийн байгууллагууд болон бусад сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэсэн үйлчилгээг бий болгож буй, байгууллагад үнэ цэн нэмдэг үндсэн үйл ажиллагаа юм.

**Дэмжих үйл явц:** Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн, тасалдалгүй явуулахад шаардлагатай нөөц болон мэдээллээр хангах үндсэн үйл явцын гүйцэтгэлийг дээшлүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаанууд юм.


**Гаднаас нийлүүлж байгаа үйл явц:** Гадны нийлүүлэгч, харилцагчаас авч байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц юм.

**ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:**

- ЦССҮТ-ийн нэгдсэн менежментийн тогтолцооны үйл явцын зураглал
- Алба, тасгуудын үйл явцын зураглал
- Үйл явцын толдорхойлолт

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

ЦССҮТ-ийн нэгдсэн менежментийн тогтолцооны үйл явцын зураглал



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

## БҮЛЭГ 5. МАНЛАЙЛАЛ БА АЖИЛТНЫ ОРОЛЦОО

### 5.1 Манлайлал ба үүрэг амлалт

**Нэгдсэн менежментийн тогтолцоо бий болгоход удирдлагын манлайлал, хүчин чармайлт маш чухал үүрэгтэй. Тэд байгууллагын зорилгоо тодорхойлж, ажилтнуудаа үр дүнтэй ажиллахуйц дотоод орчинг нь бүрдүүлж, байнга хадгална. Манлайлал бол зөвхөн захирал, удирдлагад бус дүнд шатны удирдлагууд, албаны дарга нар гээд удирдлагын түвшний бүх ажилтнуудад хамаатай.**

#### 5.1.1 Ерөнхий зүйл

ЦССҮТ-ийн ерөнхий захирал, удирдлагын зөвлөлийн гишүүд нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлж хэрэгжүүлэх, цаашид боловсронгуй болгох чиглэлээр тууштай байр суурь баримтлан ажиллаж, хүчин чармайлт гаргаж, анхаарч ажиллахад бүх талаар дэмжлэг үзүүлэн дараах манлайлал ба үүрэг хүлээнэ. Үүнд:

а/ Төвийн алсын хараа, эрхэм зорилго, нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого, зорилт болон бусад үзэл баримтлалыг тогтвортой хэрэгжүүлэхийг дэмжиж, ажилтан, сонирхогч талуудын амь нас, эрүүл мэнд хохирохоос урьдчилан сэргийлэх, ажлын байрны эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх үүрэг хариуцлагыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн дагуу хүлээдэг.

б/ ЦССҮТ-ийн төлөв байдал (4.1), алсын хараа, эрхэм зорилго болон стратегийн зорилтод нийцүүлэн нэгдсэн менежментийн бодлого (5.2.1), зорилт (6.2)-ыг тодорхойлон хэлэлцэн зөвшилцөж, баталгаажуулсан.

с/ Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016, ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны MNS ISO 45001:2018 стандартын шаардлагыг төвийн цус цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, түгээх болон дэмжих үйл ажиллагаанд нийцүүлэн нэгтгэж, өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжих нөхцлөөр хангасан.

д/ Төвийн үйл явц болон алба, тасгийн үйл явцыг уялдуулах, учирч болох эрсдлийг үнэлэн бууруулах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ба ажилтныг аюултай тохиолдол, аюул, эрсдэл, боломжуудыг мэдээлэх явцад буруутгахаас хамгаалж, эрсдэлд суурилсан сэтгэлгээг дэмжин ажиллаж байна.

е/ Нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх, хэвийн ажиллагааг хангах ба сайжруулахад шаардлагатай нөөц (санхүүгийн, хүний нөөцийн болон бусад)-ийг тодорхойлж, бэлэн байдлыг хангана. ХЭМАБ-ын арга хэмжээнд тухайн жилийн батлагдсан төсвийн 0,5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг зарцуулдаг.

ф/ Төвийн нийт эмч, мэргэжилтэн, ажиллагсад нэгдсэн менежментийн тогтолцооны шаардлагад бүх үйл ажиллагааг нийцүүлэх ач холбогдлыг ойлгуулж, эдгээр үйл ажиллагаанд ажилтнуудыг оролцуулах, зөвлөлдөх үйл явцыг бий болгож, хэрэгжилтийг хангаж байна. (7.4)

г/ Нэгдсэн менежментийн тогтолцоо төлөвлөсөн үр дүнд хүрэх нөхцлийг бүрдүүлж ажиллаж байна. Учирч болох эрсдэл, гамшиг, гэмтэл, эрүүл мэндийн хохирлыг

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

урьдчилан тооцоолж, сэргийлэх ба эрүүл аюулгүй ажлын байр болон үйл ажиллагааг хангах үүрэг, хариуцлагыг хүлээдэг.

h/ Төвийн үйл ажиллагаанд нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхэд нийт ажилтны оролцох хувь нэмрийг ойлгуулж, ажилтнуудын оролцоог ханган, чиглүүлж, дэмжлэг үзүүлдэг.

i/ Нэгдсэн менежментийн тогтолцооны тасралтгүй сайжруулалтыг хангах, сайжруулах санал, сайжруулалтын үр дүнг хэлэлцэн тодорхойлж, үнэлж урамшуулна. Сайжруулалтыг дэмжих зорилгоор журманд Ур чадварын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тусгаж, урамшуулал олгон ажиллаж байна.

j/ Бусад холбогдох чиг үүргийг дэмжихээс гадна чанарын болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх санаачлага, шийдвэрийг гарган, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардлагатай төсвийг шийдвэрэлж, үр дүнд хүрэх нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

к/ Үйл явцын арга, эрсдэлд суурилсан сэтгэлгээг дэмжиж, ажилтныг аюултай тохиолдол, аюул, эрсдэл, боломжуудыг мэдээлэх явцад буруутгахаас хамгаалах талаар холбогдох журамд тусган хэрэгжүүлдэг.

l/ Байгууллагын ХЭМАБ-ийн зөвлөл, Удирдлагын зөвлөл, Үйлдвэрчний эвлэл болон бусад орон тооны бус алба, баг, хороо, зөвлөлийн үйл ажиллагаанд ажилчдыг оролцуулдаг. Мөн шийдвэр гаргалтад ажиллагсдын оролцоог нэмэглүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

m/ Байгууллагад ажилтны эмчийг томилон, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, нэмэлт шинжилгээнд тогтмол хамруулж, чийрэгжүүлэлтийн кабинет, стрессын булан байгуулах, ажиллагсдадын хоол үйлдвэрлэл, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх зэргээр ажиллагсдадын эрүүл мэндэд анхаарч, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэргээр өөрийн хариуцлагын хүрээнд манлайллыг үзүүлж байна.

Харин төвийн албаны дарга, тасгийн эрхлэгч, эмч, мэргэжилтэн, ажиллагсад бүр хариуцсан үүрэгт ажлаа зөв, заавар, журмын дагуу хийн, үр дүнг бүртгэн баримтжуулж, шууд удирдлагад мэдээлж, ямар нэг асуудал гарвал нэн даруй мэдээлж, шуурхай арга хэмжээг төгс хэрэгжүүлэх зэргээр илэрнэ.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Үүрэг амлалтын хуудас

### **5.1.2 Хэрэглэгчид төвлөрөх**

Төвийн Ерөнхий захирал, удирдлагын зөвлөлийн гишүүд, үйлчлүүлэгч болох цусны донор, цус цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллага, эмчлүүлэгч, лавлагаа лабораторийн тусламж үйлчилгээ авч байгаа ард иргэдийг дээдэлсэн, хэрэглэгчид төвлөрөх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

а/ Төвийн үйлчлүүлэгч, хэрэглэгчийн холбогдох хууль, дүрэм журам, заавраар зохицуулсан шаардлагыг тодорхойлж, үйлчлүүлэгч, хэрэглэгч, эмч мэргэжилтэн, ажиллагсад мэдээлж, ойлгуулж, шаардлагыг тогтвортой мөрдөж ажилладаг. Мөн

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

үйлчлүүлэгч иргэн, байгууллагын эрх, үүргийг тодорхойлж, төвийн цахим болон мэдээллийн самбарт байрлуулж, эмч ажиллагсад хэрэгжүүлэн мөрдөж байгаад албаны дарга, тасгийн эрхлэгч нар хяналт тавьж, үр дүнг тооцож ажилладаг.

б/ Төвийн үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүн, үзүүлж буй тусламж үйлчилгээ нь холбогдох стандарт, дүрэм, журам, зааварт нийцэж, тохирсон байна. Цусны донор сонгох шалгуур, ЦЦБ-д тавигдах өвөрмөц үзүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/373 дугаар тушаалын хавсралт, үндэсний фармакопейд тодорхойлж баталгаажуулсан. Сайдын тушаалд заагдсан давтамжаар цусан бүтээгдэхүүнд чанарын хяналтын шинжилгээг хийж баримтжуулж байна.

Алба тасгууд үйл ажиллагаа хэвийн, зөв явагдахад учирч болох эрсдэлүүдийг тодорхойлж сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд нөлөөлөх эрсдэл болон боломжуудыг тодорхойлон, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг.

с/ Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхаарч, манлайлах үүргээ цаг ямагт биелүүлдэг. Алба, тасаг бүр гадаад болон дотоод үйлчлүүлэгчээс санал хүсэлтийг тогтмол цуглуулж, нэгтгэн, хамт олноороо хэлэлцэн түүний дагуу засах, сайжруулах ажлыг хэрэгжүүлж ажиллана. Зарим тогтолцоотой холбоотой томоохон асуудлыг удирлагын зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ. Төвийн хүний нөөцийн ажилтан ажиллагсдаас, алба тасаг бүр өөрийн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, санал, хүсэлтийг бүх хэлбэрээр авч, нэгтгэн дүгнэж, сайжруулах саналын хамт удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлж, шийдвэрийг хэрэгжүүлэн үр дүнг тооцож, илтгэж ажилладаг.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Мөнгөн урамшуулал олгох журам
- Сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны журам
- Өргөдөл, санал, гомдол хүлээн авч шийдвэрлэх журам

## 5.2 Бодлого

### 5.2.1 Нэгдсэн менежментийн бодлого боловсруулах

1. MNS ISO 9001:2016-д: Дээд удирдлага:

а/ байгууллагын зорилго, төлөв байдалд тохирсон, стратегийн чиглэлийг дэмжсэн;

б/ чанарын зорилтуудыг тогтоох, үндэслэл, боломжийг хангасан;

с/ холбогдох шаардлагыг биелүүлэх үүргийг тусгасан;

д/ чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулах үүргийг тусгасан чанарын бодлогыг бий болгож, хэрэгжүүлж мөрдөнө.

2. MNS ISO 45001:2018-д Дээд удирдлага:

**а/ байгууллагын зорилго, цар хэмжээ, төлөв байдал болон ХЭМАБ-ын эрсдэл ба боломжуудын онцлог шинж чанарт тохирсон, гэмтэл ба/ эсвэл эрүүл мэндийн хохирлоос сэргийлэхийн тулд ажлын аюулгүй, эрүүл нөхцлөөр хангах үүрэг амлалт;**

**б/ ХЭМАБ-ын зорилтуудыг тогтоохуйц агуулга, хүрээтэй байх;**

**с/ хууль тогтоомжийн шаардлага болон бусад шаардлагыг биелүүлэх үүрэг амлалт;**

**д/ аюулыг арилгах ба ХЭМАБ-ын эрсдлийг бууруулах үүрэг амлалт;**

**е/ ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог байнгын сайжруулах үүрэг амлалт;**

**ф/ ажилтнуудын, хэрэв байгаа бол тэдний төлөөллийн оролцоог хангах ба зөвлөлдөх үүрэг амлалт бүхий ХЭМАБ-ын бодлого бий болгох, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангана.**

ЦССҮТ-ийн Ерөнхий захирал ба удирдлагын зөвлөл, төвийн эмч, мэргэжилтнүүд, удирдлагын зөвлөл хэлэлцэн дараах байдлаар томьёоллоо.

**Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого:**

Төвийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэн, чанарын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо (Цаашид Нэгдсэн менежментийн тогтолцоо гэх)–г байнга сайжруулж, аюулыг илрүүлэн, эрсдлийг бууруулж, үйлчлүүлэгч, ажиллагсдад ээлтэй орчинг бүрдүүлнэ.

#### **5.2.2 Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогыг мэдээлэх**

**Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого нь:**

**а/ хүртээмжтэй, баримтжуулсан мэдээлэл байна;**

**б/ байгууллагын хэмжээнд мэдээлэгдсэн, ойлгомжтой, хэрэглэгддэг байна;**

**с/ холбогдох сонирхогч талуудад боломжоороо хүртээмжтэй байна.**

**д/ Хамааралтай, тохиромжтой байна.**

**ЦССҮТ-ийн нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогыг дараах байдлаар мэдээлнэ. Үүнд:**

а/ нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогын баримтжуулсан мэдээллийг Ерөнхий захирлаар батлуулж, төвийн хэмжээнд нийт ажилтнуудад танилцуулж, ажилтан бүрд цаасан болон цахим хэлбэрээр хүртээмжтэй байдлаар түгээсэн.

б/ Цахим хуудас, мэдээллийн самбарт мэдээлэх байдлаар нийт эмч, мэргэжилтэн, ажиллагсдад мэдээлж, ажлын байрны тодорхойлолтод тусгасан.

с/ Сонирхогч талуудад нээлттэй мэдээлж, төвийн цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулсан.

### **5.3 Зохион байгуулалтын үүрэг, хариуцлага, эрх мэдэл**

**Дээд удирдлага холбогдох чиг үүрэгт хамаарах хариуцлага, эрх мэдлийг хуваарилж, байгууллагын хэмжээнд бүх түвшинд таниулсан байх ба баримтжуулсан мэдээлэл байдлаар мөрдөж хадгална. Байгууллагын бүх түвшний ажилтан өөрийн хяналтанд байдаг ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны асуудлуудыг хариуцна.**

**ТАЙЛБАР: Хариуцлага ба эрх мэдлийг тохоон хуваарилсан хэдий ч ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны үйл ажиллагааны эцсийн хариуцлагыг дээд удирдлага хүлээнэ.**

**Дээд удирдлага:**

**а/ Чанарын болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо энэхүү олон улсын стандартын шаардлагад тохирсон байх;**

**б/ Үйл явцууд нь төлөвлөсөн үр дүнд хүрэх нөхцлийг хангах;**

**с/ Чанарын болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны гүйцэтгэл болон сайжруулах боломжууд(10.1)-ын талаар, тухайлбал дээд удирдлагад тайлагнах;**

**д/ хэрэглэгчид хандсан байх явдлыг байгууллагын хэмжээнд дэмжих;**

**е/ Чанарын менежментийн тогтолцооны өөрчлөлт нь төлөвлөгдөж, хэрэгжих үед чанарын менежментийн тогтолцооны нэгдмэл байдлыг хангах асуудлуудаар хариуцлага, эрх мэдлийг хуваарилна.**

Төвийн Ерөнхий захирал нь “ЦССҮТ-ийн дүрэм, бүтэц батлах тухай” ЭМС-ын тушаалаар батлагдсан дүрэм, бүтцэд нийцүүлэн Нэгдсэн менежментийн тогтолцооны баримт бичиг, алба, тасгийн чиг үүрэг, холбогдох хууль, эрхзүйн актаар олгогдсон үүрэг, хариуцлага, эрх мэдлийг хуваарилж, ажлын байрны тодорхойлолт, MNS ISO 10013:2001 стандартын дагуу журманд тусган, тушаалаар баталгаажуулж, төвийн хэмжээнд мэдээлж, ил тод байдлыг ханган ажилладаг.

Ерөнхий захирлын баталсан “ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны үүрэг, хариуцлага, эрх мэдлийн матриц”-ыг мөрддөг.

Төвийн Ерөнхий захирал нь хариуцлага, эрх мэдлийг хуваарилахдаа:

а/ Хариуцсан ажил, үүргийг нэгдсэн менежментийн тогтолцооны олон улсын стандартын шаардлагад нийцүүлж ажиллах ба шаардлагатай чадамжийг тасралтгүй хөгжүүлэх;

б/ Төвийн үндсэн болон дэмжих үйл явцуудын хүрээнд менежментийн тогтолцооны нэгдмэл байдал, тасралтгүй сайжруулалтыг хангах үйл явцын урсгалыг хянаж нэгтгэх, стандартаас санал болгосон арга хэрэгслүүд болох үйл явцын арга, PDCA тасралтгүй сайжруулалтын мөчлөг, эрсдэлд суурилсан сэтгэлгээг ойлгож, бүх шатанд хэрэглэх;



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

с/ Төвийн эмч, мэргэжилтэн, ажиллагсдаас ирүүлсэн нэгдсэн менежментийн тогтолцооны гүйцэтгэл болон сайжруулах боломжуудын талаарх санал, сайжрал, дэвшлийг нэгтгэн дээд удирдлагад мэдээлж, тайлагнах;

д/ Төвийн үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүн болон цусны донор, эмнэлэг, ард иргэдэд үзүүлж буй тусламж, үйлчилгээ нь хэрэглэгчид төвлөрсөн байж, тэдний хэрэгцээ ба хүлээлтийг хангахыг зорьж ажилладаг. Мөн хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэн, сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмолжуулах, сэтгэл ханамжийн судалгааг авч, дүн шинжилгээ хийх нөхцлийг хангах;

е/ Чанарын менежментийн тогтолцооны нэгдмэл байдлыг хангах асуудалд нийцүүлсэн байх асуудлуудаар эрх мэдлийг оновчтой хуваарилна.

#### **5.4 Ажилтнуудын оролцоо ба зөвлөлдөөн**

**Байгууллага нь ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, гүйцэтгэлийн үнэлгээ ба сайжруулалтын арга хэмжээнд боломжтой бүх түвшин ба чиг үүрэг бүхий ажилтнуудыг, байгаа бол, ажилтнуудын төлөөллийг оролцуулах, зөвлөлдөх үйл явц(үүд)-ыг бий болгож, хэрэгжүүлж, хэвийн ажиллагааг хангана.**

Төв нь:

а/ Нийт ажиллагсдыг стандартын мэдлэг олгох М1 түвшний сургалт болон ХНХЯ-ны 2019 оны А/370 дугаар тушаалын дагуу нийт ажиллагсдын сургалтанд хамруулсан.

б/ ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны баримт бичгүүдийг боловсруулахдаа ойлгоход хялбар, товч тодорхой, зураг, зураглал бүхий байдлаар боловсруулж, цахим санд оруулсан ба ажиллагсад тухай бүр нэвтрэх боломжийг бүрдүүлсэн.

с/ Ажилтнуудын оролцоог бүрэн хангахын тухайд удирдлагын үйлчлүүлэгч, ажилтныг хүлээн авч уулзах хуваарь гарган, сэтгэл ханамжийн судалгааг хагас жил бүр авч нэгтгэдэг ба оролцоонд учрах саад бэрхшээлийг тодорхойлж, жил бүр дүн шинжилгээ хийдэг.

д/ Дараах асуудлуудыг удирдлагын бус ажилтантай зөвлөлдөж, шийдвэр гаргахыг чухалчилдаг.

1. Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлох
2. Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого тодорхойлох
3. Зохион байгуулалтын үүрэг хариуцлага, эрх мэдлийг боломжтой байдлаар тохоон хуваарилахад /5.3/
4. Хууль тогтоомжийн шаардлага ба бусад шаардлагыг хэрхэн биелүүлэхийг тодорхойлох /6.1.3/
5. Нэгдсэн менежментүүдийн зорилтуудыг тодорхойлох ба тэдгээрийн биелэлтийг төлөвлөх /6.2/
6. Бусдаар ажил гүйцэтгүүлэхэд, худалдан авагч ба гэрээлэгчдэд тавих боломжтой хяналтыг тодорхойлох /8.1.4, 8.1.5, 8.1.6/
7. Байнгын хяналт, хэмжилт, үнэлгээг юунд хийхийг тодорхойлох /9.1.1/

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

8. Аудитын хөтөлбөрийг төлөвлөх, бий болгох, хэрэгжүүлэх, хэрэгжилтийн хэвийн байдлыг хангах 9.2.2/
9. Байнгын сайжруулалтын үйл явцыг бий болгоход /10.2.2./

е/ Дараах асуудлаар удирдлагын бус ажилчдыг оролцуулдаг.

1. Ажилтнуудыг оролцуулах ба зөвлөлдөх хэрэгслийг тодорхойлох
2. Аюулыг тогтоох ба эрсдэл боломжийг үнэлэх /аюул мэдээлэх хуудас, эрсдлийн үнэлгээ/ /6.1.1,6.1.2/
3. Аюулыг арилгах ба ХЭМАБ-ын эрсдлийг бууруулах /6.1.4/
4. Чадамжийн шаардлага, сургалтын хэрэгцээ, сургалт, сургалтын үнэлгээг тогтоох /7.2/
5. Юуг мэдээлж, танилцуулах, түүнийг хэрхэн хийж гүйцэтгэхийг тодорхойлох /7.4/
6. Хяналтын арга хэмжээнүүдийг тодорхойлох, тэдгээрийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хэрэглэх /8.1, 8.1.3, 8.2/
7. Аюултай тохиолдол ба үл тохирлыг судлах, залруулах арга хэмжээг тодорхойлох /10.1/

## **6. Төлөвлөлт**

### **6.1.1 Эрсдэл болон боломжуудыг авч үзэх арга хэмжээ**

**6.1.1 Байгууллага нь чанарын менежментийн тогтолцоог төлөвлөхдөө 4.1-д заасан асуудлууд (байгууллагын төлөв байдал), 4.2-т заасан шаардлага (сонирхогч талууд), 4.3 (ХЭМАБ-йн хамрах хүрээ)-г анхаарч үзэх ба дараах асуудалд хамаарах эрсдэл болон боломжуудыг тодорхойлно:**

**а/ чанарын болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо төлөвлөсөн үр дүнд хүрнэ гэсэн баталгаа гаргах**

**б/ хүсч буй үр дүнг дээшлүүлэх**

**с/ хүсээгүй үр дүнгээс урьдчилан сэргийлэх буюу бууруулах**

**д/ байнгын сайжруулалтад хүрэх асуудлаар эрсдэл болон боломжуудыг авч үзнэ.**

ЦССҮТ нь нэгдсэн менежментийн тогтолцоог төлөвлөхдөө төвийн гадаад, дотоод асуудал, сонирхогч талуудын шаардлага, хамрах хүрээнд үндэслэнэ. Үүнд:

- а) Нэгдсэн менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, хадгалж, хөгжүүлснээр аюулгүй, эмчилгээний үр дүнтэй цус, цусан бүтээгдэхүүнийг хүрэлцээтэй хэмжээгээр үйлдвэрлэж, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг тогтмол нийлүүлэх эмч, ажиллагсад, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хамгаалан, эрүүл ажлын нөхцөл бий болгож, хадгалах, үр дүнд хүрэх.
- б) Нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, хөгжүүлснээр төвийн эмч, мэргэжилтэн, ажилтан бүр хийж буй ажлаа цаг хугацаанд нь зөв, бүрэн төгс, чанартай хийж байж төвийн эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хувь нэмрээ оруулна гэдгийг ойлгон өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж, хэвших
- с) Мөн тулгарч болох эрсдлийг тодорхойлж, хүсээгүй үр дүнгээс урьдчилан сэргийлэх ба бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

- d) Үйл явц, ажилбарыг байнга сайжруулахад байгаа боломж болон үүсч болох эрсдэлийг тооцоолон үзэж төлөвлөлт хийх зэргээр төлөвлөнө.

Төвд Ерөнхий захирлын 2022 оны А/03 дугаар тушаалын дагуу байгуулагдсан орон тооны бус баг, зөвлөл болон ХЭМАБ-ын зөвлөл ажилладаг.

Алба, тасгууд үйл ажиллагааны онцлогтоо тохируулан эрсдэл, боломжоо тодорхойлон, бага, дунд эрсдэлүүдийг тасаг, нэгжийн түвшинд эрсдлийг хянана. Өндөр, ноцтой эрсдлүүдийг нэгтгэн “ЦССҮТ-ийн эрсдлийг бууруулах төлөвлөгөө” боловсруулан батлуулж ажилладаг. MNS ISO 45001:2018 стандартын шаардлагын дагуу Аюул, эрсдлийг тодорхойлох, зохицуулах журам боловсруулан мөрдөн ажиллаж байна. Төвийн үйл ажиллагааны эрсдэл, боломжийг үйл явцын зураглалд тусган тодорхойлсон ба нэгтгэсэн байдлаар дараах ангилалын дагуу тодорхойлохоор төлөвлөсөн. Үүнд:

1. Төсөв, санхүүгийн эрсдэл
2. Мэдээллийн технологийн эрсдэл
3. Хүний нөөцийн эрсдэл
4. Үндсэн үйл ажиллагааны эрсдэл
5. Дэмжих үйл ажиллагааны эрсдэл
6. Гадаад хүчин зүйлсийн буюу бусдаас хамаарах эрсдэл
7. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэл
8. Ажилтны аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэл

Эрсдлээс сэргийлэх, боломжийг олж авах хариу арга хэмжээг авч, холбогдох үйл явцын өөрчлөлтийг төлөвлөж, хэрэгжүүлнэ. Арга хэмжээнүүд нь:

1. Эрсдэлийн эх үүсвэрийг арилгах
2. Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх
3. Эрсдэл үүсгэгчийг өөр зүйлээр орлуулах, зайлсхийх
4. Эрсдэлийг хуваалцах
5. Бусдад шилжүүлэх
6. Нөлөөллийг зөвшөөрөх хэмжээнд хүргэж, тогтоон барих

Эрсдэл боломжийг бүртгэж сан бүрдүүлнэ. Авсан арга хэмжээний үр нөлөөг үнэлнэ.

## **6.1.2 Аюулыг олж тогтоох ба эрсдэл болон боломжуудад үнэлгээ өгөх**

### **6.1.2.1. Аюулыг олж тогтоох**

Төв нь аюулыг мэдээлэх хуудсыг байгууллагын хэмжээнд ашигладаг ба аюулыг үнэлэх, эрэмбэлэх, арилгах эсвэл ХЭМАБ-ын эрсдлийг бууруулах зорилгоор ажлын байран дах ба ажилтанд учрах аюулыг таньж мэдэх ба ойлгоход туслахыг ухамсарласан байдаг ба нийт ажилтнуудад аюул, эрсдлийн талаар сургалтыг жилд 2 удаа зохион байгуулдаг.

Төв нь аюулыг урьдчилан тодорхойлох үйл явцыг бий болгож, нэвтрүүлж хөгжүүлсэн. Үүнд:

- a) Байнгын ба байнгын бус үйл ажиллагаанууд ба нөхцлүүд
- Ажлын зохион байгуулалт, нийгмийн хүчин зүйл /ажлын ачаалал, ажлын цаг, ажлын байрны дарамт, / манлайлал, байгууллагын соёл

- b) Хүний хүчин зүйлс
  - Хэвийн болон хэвийн бус нөхцөл /нөхцөлийн нэмэгдэл, ажлын хорогдолтой цаг
- c) Шинэ эсвэл өөрчлөгдсөн аюул
  - Төвийн гадна, дотно гарсан аюултай тохиолдлууд үүнд онцгой байдал тэдгээрийн шалтгаан
- d) Болзошгүй онцгой байдлын нөхцөлд
  - Онцгой байдлын нөхцөл –КОВИД 19 хөл хорио, ХСХ дэглэм мөрдөлт
- e) Хүмүүс
  - Ажлын байранд нэвтэрч болон үйл ажллагаанд оролцож буй ажилтнууд, гэрээт ажилтан, зочид
  - Ажлын байрны ойролцоо байгаа байгууллагын үйл ажиллагаанд өртөж болох хүмүүс
  - Тухайн байрлалд байгаа боловч байгууллагын шууд удирдлаган дор байдаггүй ажилтнууд
- f) Аюулын тухай ойлголт, мэдлэгийн өөрчлөлт

#### **6.1.2.2. ХЭМАБ-ын эрсдэл ба ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны бусад эрсдлийг үнэлэх**

Төв нь дараах үйл явцуудыг бий болгож, нэвтрүүлж, хэрэгжүүлнэ.

- a) Хууль тогтоомжийн шаардлага, бусад шаардлагууд ба хэрэглэж байгаа хяналтын үр нөлөөг авч үзэх, олж тогтоосон аюулын учруулж болох эрсдэлд үнэлэлт өгөх
- b) ХЭМАБ-ын тогтолцоог бий болгох, нэвтрүүлэх, ажиллуулах, хэвийн ажиллагаатай холбоотой 4.1-д заасны дагуу тодорхойлсон асуудлууд, мөн 4.2-т заасны дагуу тодорхойлсон хэрэгцээ ба хүлээлтээс үүсэх эрсдлийг олж тогтоох, үнэлэлт хийх

ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны эрсдлүүдийг үнэлэхдээ дараах үйл явцуудыг анхаарна.

1. Өдөр тутмын үйл ажиллагаа ба шийдвэрүүд
2. Гадаад асуудлууд
3. Өдөр тутмын үйл ажиллагааны нөлөөнд өртсөн ажилтнуудтай тухай бүрт нь зөвлөлдөх
4. Хууль тогтоомжийн шаардлага болон бусад шаардлагуудад мониторинг хийх ба харилцан мэдээлэх
5. Одоо мөрдөгдөж байгаа болон өөрчлөгдөж байгаа хэрэгцээнд нийцэх нөөцөөр хангах асуудлуудыг багтаана.

#### **6.1.2.3. ХЭМАБ-ын боломжууд ба ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны бусад боломжуудыг үнэлэх**

Төв нь дараах үйл явцуудыг бий болгож, нэвтрүүлж, хөгжүүлнэ.

- a) ХЭМАБ-ын гүйцэтгэлийг сайжруулах боломжууд
  1. Ажил, ажлын зохион байгуулалт, ажлын орчинг ажилтнуудад таруулах боломжууд
  2. Аюулыг устгах болон ХЭМАБ-ын эрсдлийг бууруулах боломжууд

3. Төвийн бодлого, үйл явц, үйл ажллагаанд хийхээр төлөвлөсөн өөрчлөлтүүд

б) ХЭМАБ-ын тенезментийн тогтолцоог сайжруулах боломжууд

### **6.1.3 Хууль тогтоомжийн шаардлага ба бусад шаардлагыг тодорхойлох**

Төв нь дараах зүйлст чиглэсэн үйл явцуудыг бий болгож, хэрэгжүүлж, хэвийн ажиллуулна.

- а) Хууль тогтоомжийн шаардлага ба бусад шаардлагыг тодорхойлох болон ажилтнуудад хэрэгцээг нь мэдээлж таниулах
- б) Хүчин төгөлдөр хууль тогтоомжийн шаардлага болон бусад шаардлагуудыг тодорхойлж, үнэлэлт өгөх
- в) Төв нь хууль тогтоомжийн шаардлагууд ба бусад шаардлагын талаар баримтжуулсан мэдээллийг мөрдөж болон хөтөлж хадгалах ба ингэхдээ аливаа өөрчлөлтүүдийг тусгасан хэмжээнд шинэчлэгддэг байх явдлыг хангана.

### **6.1.4 Төлөвлөх арга хэмжээ**

ЦССҮТ нь дараах арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- а) Эрсдэл болон боломжуудад чиглэсэн арга хэмжээг төлөвлөнө. Эрсдэл, гамшиг үүсгэх шалтгааныг тодорхойлох, эрсдэлийн эх үүсвэрийг арилгах, эрсдэлийн магадлал буюу үр дагаврыг өөрчлөх, эрсдэлийг хуваалцах, шийдвэрийг ил тод байлгах зэргээр эрсдэлийг сэргийлэх буюу бууруулах арга хэмжээг авна. Боломж нь шинэ технологи, туршлагыг нэвтрүүлэх, нутагшуулах, шинэ бүтээгдэхүүн гаргах, шинэ зах зээл нээх, шинэ хэрэглэгчид чиглүүлэх, түншийн харилцаа бий болгох төвийн болон хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд чиглэсэн бусад бодит тааламжтай бололцоонуудыг ашиглана
- б) Хэрхэн яаж төлөвлөсөн арга хэмжээнүүдийг:
  - 1) ХЭМАБ-ын тогтолцооны үйл явцуудтай уялдах, холбон нэгтгэж хэрэгжүүлэхийг
  - 2) Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн үр нөлөөг үнэлэхийг тусгаж өгнө. Хянаж, үнэлэх.

Үйл ажиллагаа явуулахад нөлөөлж болох эрсдэл, боломжуудыг тооцоолон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа нь үйлдвэрлэх цус, цусан бүтээгдэхүүн, үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарын шаардлагад нийцэхэд үзүүлэх нөлөөлөлтэй уялдсан байна. Жил бүрийн эхэнд ЗГ-аас ЭМ-ийн талаар хэрэгжүүлж байгаа бодлого, төвийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөнд тулгуурлан төвийн, алба, тасаг, орон тооны бус алба, баг, комисс жилийн үйл ажиллагааны болон үндсэн тасгууд цус цуглуулалт, шинжилгээ, ЦЦБ үйлдвэрлэлийн төлөвлөгөө боловсруулна. Эдгээр төлөвлөгөөг боловсруулахдаа төвийн боломж, давуу тал, сул тал эрсдэл, аюулыг тооцоолон аль болох аюул, эрсдлээс сэргийлэн үйл ажиллагаагаа төлөвлөнө.

Төвийн болон алба тасгууд үйл ажиллагааны /үндсэн дэмжих үйл ажллагаа, аюул эрсдлээс сэргийлэх, чанар сайжруулахад чиглэсэн үйл ажллагаанууд тусгагдсан байна/ болон тоон үзүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан хамт олноороо хэлэлцүүлэн төвийн захирлаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө
- Эрсдлийг бууруулах төлөвлөгөө

## **6.2 Чанарын болон ХЭМАБ-ын зорилтууд ба төлөвлөлт**

### **6.2.1 Байгууллага нь Чанарын менежментийн тогтолцоонд шаардлагатай холбогдох чиг үүрэг, түвшин, үйл явцууд дахь болон ХЭМАБ-ын гүйцэтгэлийг сайжруулах ба дэмжиж тогтворжуулахын тулд чанарын зорилтуудыг тогтооно.**

Төвийн нэгдсэн менежментийн зорилтуудыг тодорхойлохдоо дараах шаардлагыг хангаж боловсруулсан ба төвийн Ерөнхий захирлын тушаалаар баталсан.

а/ Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлоготой уялдуулсан;

б/ Хэмжигдэхүйц байхаар тодорхойлсон;

с/ Байгууллагын үйл ажиллагаатай хамаарах шаардлагыг авч үзсэн; /эрсдэл боломж, ажилтнуудын төлөөлөлтэй зөвлөлдсөн үр дүн/

д/ Хэрэглэгч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн;

е/ Жил бүр тогтмол хянагддаг;

ф/ Мэдээлэгдэх боломжтой;

г/ Шаардлагатай тохиолдолд шинэчлэгддэг;

#### **Нэгдсэн менежментийн тогтолцооны зорилт:**

- 1. Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартын шаардлагыг хангаж, сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламж үйлчилгээ үзүүлж, тасралтгүй сайжруулах**
  - ISO 9001:2015 Чанарын менежементийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартуудын дотоод аудитыг жил бүр 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, илэрсэн үл тохирол, сайжруулах зөвлөмжийн дагуу залруулах арга хэмжээг заавал авч ажиллана.
  - Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартын хөндлөнгийн аудитад жил бүр хамрагдаж, илэрсэн үл тохирол, сайжруулах зөвлөмжийн дагуу залруулах арга хэмжээг авч ажиллана.
  - Үйлчлүүлэгчийн санал гомдол, сэтгэл ханамжийн судалгааг олон талт хэлбэрээр зохион байгуулж, хариу арга хэмжээ авч ажиллана.
  - Ажиллагсдын чадамжид тавих шаардлагыг шинэчлэн, хүний нөөцийн чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
  - Жил бүр үйл ажиллагааны эрсдэл боломжийг тооцоолж, аюулыг арилган, тогтмол сайжруулалт хийж ажиллана.
  - Нэгдсэн менежементийн тогтолцооны чиглэлээр нийт ажиллагсдад жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулан, ажиллагсдын оролцоог хангаж ажиллана.

**2. Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, аюулгүй, үр дүнтэй цус, цусан бүтээгдэхүүнээр тасралтгүй хангана.**

- Цусны донорын эгнээг өргөжүүлж, байнгын донорын эзлэх хувийг 60%-иас дээш байлгана.
- Лабораторийн шинжилгээний 5–аас доошгүй олон улсын болон үндэсний чанарын гадаад үнэлгээнд тогтмол хамрагдана.
- ЦЦБ-ийг чанарын болон ариун чанарын шинжилгээнд хамруулж, шинжилгээгээр тэнцэлтийг 95%-иас дээш байлгана.

**6.2.2 Нэгдсэн менежментийн тогтолцооны зорилтуудад хүрэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, шаардагдах нөөцийг шалгаж магадлана.**

Төвийн нэгдсэн менежментийн тогтолцооны зорилтууд, түүнд хүрэхэд чиглэсэн төлөвлөгөө нь нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогыг хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулахад чиглэгдэх дараах маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр сард гаргаж, баталгаажуулан, төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд давхар тусган, Захиргаа маркетингийн албанд хянуулж, Ерөнхий захирлаар батлуулж, хэрэгжилтийг улирал, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллана.

№	Хэрэгжүүлэх арга зам	Хариуцах эзэн	Дуусах хугацаа	Шаардагдах нөөц	Зорилтот үр дүн	Биелэлт (жил, улирал)
1	2	3	4	5	6	7

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр
- Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого, зорилт
- Төвийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө

**6.3 Өөрчлөлтийг төлөвлөх**

**Хэрэв байгууллага чанарын менежментийн тогтолцоондоо өөрчлөлт хийх шаардлагатай гэж тодорхойлсон бол түүнийгээ төлөвлөнө.**

Төв нь менежментийн тогтолцоонд өөрчлөлт хийх шаардлагатай гэж тодорхойлсон бол түүнийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ. Тухайлбал, жил бүр САЗ, АЗ, ТТАЗ-ыг хянаж, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт хийх ба өөрчлөлтийг төлөвлөхдөө дараах зүйлсийг авч үзнэ. Үүнд:


a/ Өөрчлөлт хийх зорилго, түүнээс гарах боломжит үр дагавар /ээрэг – боломж, сөрөг-эрсдэл/

b/ Чанарын менежментийн тогтолцооны нэгдмэл байдал, үйл явцын уялдаа холбоо хамаарал / ЦЦБ, тусламж үйлчилгээний чанарт нөлөөлөх байдал/

c/ Нөөцийн бэлэн байдал /хүн, дэд бүтэц, орчин, мэдлэг, санхүү/

d/ Үүрэг хариуцлага ба эрх мэдлийн хуваарилалт, дахин хуваарилалт зэрэг болно.

**Өөрчлөлт хийх үйл явц:**



**7. Дэмжих үйл явц**

**8.1 Нөөц**

**7.1.1. Ерөнхий зүйл**

**Байгууллага нь нэгдсэн менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, тасралтгүй сайжруулахад шаардлагатай нөөцийг тодорхойлж хангана. Чанарын менежментийн тогтолцооны хүрээнд дараах асуудлыг авч үзнэ:**

**а/ дотоод нөөц боломж ба хязгаарлагдмал байдал**

**б/ гадны нийлүүлэгчээс авах шаардлагатай зүйлс**

Төв нь нэгдсэн менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, үр нөлөөг нь байнга сайжруулах дараах үйл явцыг тодорхойлсон. Үүнд:

1. Стратегийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх
2. Тусламж үйлчилгээг эрх тэгш, хүртээмжтэй хүргэх
3. Сонирхогч талуудын шаардлагад нийцэх замаар сэтгэл ханамжийг дээшлүүлэх
4. Эрүүл, аюулгүй ажлын байр бий болгох
5. Эрүүл ажилтан байх хандлагыг төлөвшүүлэх

Эдгээр үйл явцад шаардагдах нөөцийг дараах байдлаар тодорхойлон ханган ажиллаж байна.

Дотоод нөөц боломж болон хязгаарлагдмал байдал	Гаднаас авах нөөцийн хэрэгцээ
<ul style="list-style-type: none"><li>• Дадлага туршлагатай хүний нөөц</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• Төсвийн санхүүжилт</li></ul>



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

<ul style="list-style-type: none"><li>• Дэд бүтэц<ul style="list-style-type: none"><li>• Барилга байгууламж</li><li>• Тоног төхөөрөмж</li><li>• Программ хангамж</li><li>• Тээврийн хэрэгсэл</li><li>• Мэдээлэл харилцаа холбооны хэрэгсэл /хэмжих хэрэгслүүд/</li><li>• Лаборатори, сургалт дадлагын бааз</li></ul></li><li>• Санхүүгийн нөөц /Давсан орлого</li><li>• Ажилчдын хоолны газар</li><li>• Чийрэгжүүлэлтийн өрөө</li><li>• Ажиллагсдын амрах хэсэг</li><li>• Халдваргүйтгэл</li><li>• Мэдлэг ойлголт</li><li>• Дүрэм заавар</li><li>• Нөхцлийн үнэлгээ</li><li>• Хувийн хамгаалах хувцас хэрэглэл</li><li>• Дархлаажуулалт</li><li>• Нийт ажиллагсдын эрүүл мэндийн үзлэг</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• Тоног төхөөрөмж, бараа материалын худалдан авалт</li><li>• Программ хангамж</li><li>• Донорын хүнс түгээх үйлчилгээ</li><li>• Гадны төсөл, гэрээт ажил</li><li>• Барилга байгууламж, техник хэрэгслийн засвар үйлчилгээ</li><li>• Интернетийн үйлчилгээ</li><li>• Харуул хамгаалалтын үйлчилгээ</li><li>• Ажилчдын хоолны газар</li></ul>
--	---

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Жилийн төсөв
- Худалдах, худалдан авах гэрээ
- Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээний дүн
- Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан тайлан

**7.1.2. Хүмүүс**

**Байгууллага нь чанарын менежментийн тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлэх, үйл явцыг хянахад шаардлагатай хүний нөөцийг тодорхойлж хангана.**

Төв нь нэгдсэн менежментийн тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлэх, үйл явцыг хянахад шаардлагатай хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

Төвийн үйл явц, ажилбартай уялдуулан ажлын байр бүр дээр ажиллах орон тоог тогтоож, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Ерөнхий захирал баталдаг. Эмч, ажилтны ажиллах орчин, нийгмийн асуудлыг байнга сайжруулж, хүний нөөцийг хадгалах бодлого барьж ажиллах ба хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажилладаг.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Төвийн ажиллагсдын орон тоо баталсан тушаал
- Ажлын байрны жагсаалт, албан тушаалын тодорхойлолт

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

- Ажилтныг сонгон шалгаруулах, дадлагажуулан сургах, туршилтаар ажиллуулах, үндсэн ажилтнаар томилох журам
- Шинэ ажилтныг сургах журам

### 7.1.3. Дэд бүтэц

**Үйл явцыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирсон байлгахад шаардлагатай дэд бүтцийг байгууллага тодорхойлж, хангаж, хадгална.**

ЦССҮТ нь цус, сийвэн, эс цуглуулах, шинжлэх, ЦЦБ үйлдвэрлэх, хадгалах, олгох, сургалт зөвлөгөө болон бусад дэмжих үйл ажиллагаанд шаардлагатай дэд бүтцийг дараах байдлаар тодорхойлсон:

1. Барилга, байгууламж
  - Төвийн 1-р байр /цус цуглуулах өрөө, эмнэлгийн лаборатори, ЦЦБ үйлдвэрлэлийн өрөө, хүйтэн өрөө, хорионы хэсэг, албан өрөө, сургалтын танхим, хурлын заал, номын сан, агуулах, амрах өрөө, цайны газар, чийрэгжүүлэлтийн кабинет, ажилчдын хувцас угаалга, усанд орох газар, жижиглэн худалдаа, цахилгааны нөөц үүсгүүр/
  - Төвийн 2-р байр /цус цуглуулах өрөө, эмнэлгийн лаборатори, гамшгийн нөөцийн өрөө, албан өрөө, агуулах, амрах өрөө, жижиглэн худалдаа, цахилгааны нөөц үүсгүүр/
  - Дүнжингарав цус цуглуулах төв /цус цуглуулах өрөө/
2. Материал ба програм хангамж зэрэг тоног төхөөрөмж
  - Donoinfo программ
  - Вр программ
  - Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний бүртгэлийн программ
3. Тээврийн нөөц
  - Эмнэлгийн зориулалтын дохиололтой машин 2ш
  - Албан хэрэгцээний хөнгөн тэрэг
4. Мэдээлэл ба харилцаа холбооны технологи
  - Утасгүй интернэт орчин Wi-fi
  - Өндөр хурдны интернэт
  - Суурин утас
  - Гар утас

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Үндсэн үйл ажиллагааны цахим мэдээлэлд засвар өөрчлөлт хийх журам
- Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах журам
- Автомашин болон зогсоол ашиглалтын журам

### 7.1.4. Үйл явцыг хэрэгжүүлэх орчин

**Байгууллага үйл явцуудыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын байдлыг хангахад шаардлагатай орчныг тодорхойлж, бүрдүүлж, хадгална.**

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

ЦССҮТ нь үйл явцуудыг хэрэгжүүлэхэд тохирох орчныг дараах байдлаар тодорхойлж, бүрдүүлж, хадгалдаг.

а/ Нийгмийн хүчин зүйл: Амар тайван, аюулгүй, ая тухтай орчин нөхцөлд ажиллах, үйлчлүүлэх боломжийг бий болгосон.

б/ Сэтгэл зүйн хүчин зүйл: Ажлын ачаалал, сэтгэл ханамж, алжаал тайлах булан, уян хатан ажлын цагийн зохицуулалт, сэтгэл зүйн чиглэлийн сургалтууд, стресс тайлах болон зөв хооллолт, эрүүл амьдралын сургалтуудыг зохион байгуулдаг.

с/ Физикийн хүчин зүйл: Ажлын байрны температур, халуун, чийг, гэрэл, агаарын урсгал, эрүүл ахуй, дуу чимээ, тоног төхөөрөмжийн ая тухтай байдалд хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэж, хяналт тавьж, сайжруулдаг.

**7.1.5. Хяналт ба хэмжилтийн нөөц**

**7.1.5.1. Ерөнхий зүйл**

**Байгууллага нь бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлагад тохирч байгааг шалгадаг хяналт, хэмжилтийг хүчин төгөлдөр, найдвартай байлгахад шаардлагатай нөөцийг тодорхойлж хангана. Нөөц дараах шаардлага хангасан байхыг байгууллага хариуцна. Баримтжуулсан мэдээллийг хадгална.**

- **Хяналт хэмжилтийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байх**
- **Зориулалтаар нь тасралтгүй ашиглах бололцоог хангасан байна.**

ЦССҮТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх хэмжих хэрэгслүүд нь шаардлагад нийцэж буйг нотлох, хяналтын ба хэмжилтийн үнэн зөв үр дүн гаргах нөөцийг тодорхойлж хангана.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ	-	Баримтжуулсан мэдээлэл /нөөц/
Цус, сийвэн, эс цуглуулах	ЭМС-ын 2020 оны А/373 тушаал “Донороос цус авах журам”	Цусны донорын эрүүл мэндийн карт, эмчийн үзлэг хийсэн бүртгэл
Цусны донор, ЦЦБ-д хийгдэх болон иммуногематологийн шинжилгээ хийх	ЭМС-ын 2020 оны А/373 тушаал “Цусны донор, ЦЦБ-ийг шинжлэх журам”	- ЦЦБ-д хийгдсэн цусны АВО, резус бүлэг, халдвар илрүүлэх, чанарын шинжилгээний протокол - ЦЦБ-ийг хорионоос чөлөөлсөн баримтжуулалт
Хэмжих хэрэгсэл баталгаажуулах	Ерөнхий захирлын 2022 оны А/101 тушаал	Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Ханган нийлүүлэгч байгууллагын шалгалт тохируулга хийх	Гэрээ, хуваарь	Тоног төхөөрөмжийг суурилуулсан, засвар үйлчилгээ хийсэн протокол
--	----------------	---

**7.1.5.2. Хэмжилтийн нэгж дамжуулалт**

**Хэмжилтийн нэгж дамжуулалтыг хангах тухай шаардлага тавигдаж байгаа, эсвэл хэмжилтийн үр дүнгийн хүчин төгөлдөр байдалд итгэл үнэмшилтэй байх нь байгууллагын үйл ажиллагааны салшгүй хэсэгт тооцогддог бол хэмжих хэрэгсэл дараах шаардлагыг хангасан байна.**

Ерөнхий захирлын 2022 оны А/101 дүгээр тушаалаар төвийн хэмжээнд шалгалт тохируулгад хамруулах шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг баталсан. Батлагдсан жагсаалтын дагуу жил бүр тоног төхөөрөмжийг Стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулахаас гадна хагас болон бүрэн автомат багаж, хэрэгслийг зориулалтын хяналтын материал, калибровка, эталон термометрээр шалгаж тохируулан баримтжуулалт хөтөлдөг. Өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэхийн өмнө холбогдох эмч, мэргэжилтнүүд шалгаж, баримтжуулдаг.

Шалгах тохируулах явцад зөвшөөрөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тасгийн эрхлэгч, холбогдох инженер техникийн ажилтанд мэдэгдэж асуудлыг шийдвэрлэдэг.

**7.1.6. Байгууллагын мэдлэг**

**Үйл явцыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирсон байлгахад шаардлагатай мэдлэгийг байгууллага тодорхойлсон байна. Энэ мэдлэгийг хадгалж, шаардлагатай хэмжээнд хүртээмжтэй байлгана. Хэрэгцээ, хандлагын өөрчлөлтөд нийцүүлэхэд шаардлагатай аливаа нэмэлт мэдлэгийг олж авах, байгаа мэдлэг дээрээ үндэслэн хэрхэн баяжуулж нэвтрүүлэх аргыг байгууллага тодорхойлно.**

ЦССҮТ нь үйл явцыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэгийг дараах байдлаар тодорхойлж, холбогдох албан тушаалтнуудад ашиглахад нээлттэй байхаар номын сан, цахим номын сан, төвийн вэб хуудсанд байрлуулсан.

Дотоод эх үүсвэрээс гаралтай мэдлэг

- ЦССҮТ-ийн бодлогын баримт бичиг
- ЦЦБ үйлдвэрлэх стандарт ажиллагааны зааврууд
- Цус сэлбэлт судлалын салбарын эрдэм шинжилгээний өгүүллүүд /хурлын эмхэтгэлүүд/
- Судалгааны ажил, гэрээт ажил, төсөл хөтөлбөр
- Үйл явцын тодорхойлолт
- Холбогдох журам, САЗ, АЗ, ТТАЗ
- Сургалтын хөтөлбөр
- Хүний нөөцийн хуримтлуулсан туршлага, мэдлэг
- Байгууллагын ололт амжилт

<ul style="list-style-type: none"><li>• Оюуны өмч /патент, ашигтай загвар/</li><li>• Үйл ажиллагааны үл тохирол</li><li>• Аливаа сайжруулалтын үр дүн</li><li>• Тусгай мэргэжлийн оргүй төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт</li></ul>
Гадаад эх үүсвэрээс гаралтай мэдлэг
<ul style="list-style-type: none"><li>• ДЭМБ-ийн удирдамж, стратеги, зөвлөмж</li><li>• Эрүүл мэндийн сайдын тушаал, журам, заавар</li><li>• Үндэсний фармакопей</li><li>• Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, семинар</li><li>• Гадаад улсад зохиогдсон уулзалт, сургалт</li><li>• Хамтарсан төсөл, хөтөлбөр</li><li>• Гадны сургалт</li></ul>

## 7.2. Чадамж

### Байгууллага нь:

**а/ Нэгдсэн менежментийн тогтолцооны гүйцэтгэл болон үр нөлөөтэй байдалд нөлөөлөх ажилтанд шаардагдах чадамжийг тодорхойлох**

**б/ Зохих боловсрол, сургалт, туршлагад үндэслэн эдгээр ажилтнуудын чадамжийг магадлах**

**с/ Боломжтой бол, шаардлагатай чадамжийг эзэмшүүлэх арга хэмжээ авах ба эдгээр арга хэмжээний үр нөлөөтэй байдлыг үнэлэх**

**д/ Чадамжийг нотлоход тохиромжтой баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.**

ЦССҮТ нь төвийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, салбарын хөгжил дэвшил болон ХЭМАБ-ын эрсдлийг удирдах, хуулийн нийцлийг хангах шаардлагатай уялдуулан ажиллагсдын чадамжийг тасралтгүй хөгжүүлэх зорилтыг тавьж ажиллаж байна.

а/ ЦССҮТ нь төвийн үйл явцад оролцож байгаа ажиллагсдын мэргэжлийн болон нэгдсэн менежментийн тогтолцооны гүйцэтгэл, үр нөлөөтэй байдалд шаардагдах чадамжийг тодорхойлж, ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусгасан.

б/ Чадамжийг магадлах ажлыг 2 жилд 1 удаа зохион байгуулна.

с/ Шинэ ажилтанд Хөдөлмөрийн аюулгүй байдлын, цусны албаны болон алба, тасгийн өвөрмөц онцлог, мэдлэг, чадамжийг батлагдсан сургалт, хөтөлбөрөөр эзэмшүүлж, сургалтын төгсгөлд тодорхой шалгуураар үнэлдэг.

д/ Төвийн ажиллагсдын чадамжийг нотлох холбогдох баримтжуулсан мэдээллийг хүний нөөцийн ажилтан бүрдүүлж, хадгалдаг.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Ажиллагсдын мэргэжлийн болоод хувь хүний чадамжуудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

№	Чадамжийн бүлэг	Чадамжийн төрөл
1	Үндсэн ур чадвар	<ul style="list-style-type: none"><li>➤ Манлайлал ба өөриймсөг сэтгэлгээ</li><li>➤ Харилцаа ба хамтын ажиллагаа</li><li>➤ Сахилга хариуцлага ба ёсзүй</li><li>➤ Хувийн зохион байгуулалт</li><li>➤ Хэлний мэдлэг /англи, орос хятад/</li><li>➤ Цахим хэрэглээ</li><li>➤ Бичиг баримт хөтлөлт, боловсруулалт</li><li>➤ Нууц хадгалах</li><li>➤ Илтгэх ба танилцуулах</li><li>➤ Авхаалж, овсгоо</li><li>➤ Суралцах ба дасан зохицох</li></ul>
2	Мэргэжлийн чадамж	<ul style="list-style-type: none"><li>➤ Тухайн жилд сургалтад хамрагдсан эсэх</li><li>➤ Гардан үйлдлийн стандарт мөрдөлт</li><li>➤ Ажлын цаг ашиглалт</li><li>➤ Тайлан мэдээг цаг хугацаандаа гаргадаг эсэх</li><li>➤ Стандарт мөрдөж ажиллах</li><li>➤ Аюулыг олж илрүүлэх, мэдээлэх</li><li>➤ ХЭМАБ өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа тухай бүрт өгдөг эсэх</li></ul>
3	Удирдах ур чадвар	<ul style="list-style-type: none"><li>➤ Бусдыг манлайлал</li><li>➤ Цагийн менежмент</li><li>➤ Хариуцлагаа ухамсарлах</li><li>➤ Уян хатан байдал</li><li>➤ Өөрийгөө сэдэлжүүлэх</li><li>➤ Харилцаа холбоо тогтоох чадвар</li><li>➤ Зөрчилдөөнийг шийдвэрлэх, хэлэлцээр хийх</li><li>➤ Багаар ажиллах</li><li>➤ Шийдвэр гаргах чадвар</li><li>➤ Шинийг санаачлах ба өөрчлөлтийг хүлээж авах</li></ul>

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Ажиллагсдын чадамжийн үнэлгээ
- Чанарын болон ХЭМАБ-ийн менежементийн тогтолцооны М1, М2, М3 сургалтанд хамрагдсан гэрчилгээ
- Дээд удирдлагын ХЭМАБ-ын сургалтанд хамрагдсан гэрчилгээ
- Нийт ажиллагсдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрсдлийн сургалтад хамрагдсан бүртгэл

### 7.3 Мэдлэг ойлголт

#### **Ажилтан дараах зүйлсийг мэдэж ойлгосон байна:**

**а/ Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого ба зорилтууд**

**б/ Нэгдсэн менежментийн тогтолцоонд тэдгээрийн оруулсан хувь нэмэр (ХЭМАБ-ын гүйцэтгэл сайжруулсны үр өгөөж)**

**с/ Нэгдсэн менежментийн тогтолцооны шаардлага хангаагүйгээс гарах үр дагавар ба үршиг**

**д/ Аюултай тохиолдлууд, тэдгээрийг судалсны үр дүн**

**е/ Тэдэнд хамаарна гэж тодорхойлсон аюул, ХЭМАБ-ын эрсдэл ба арга хэмжээнүүд**

**ф/ Амь нас ба эрүүл мэндэд нь зайлшгүй ба ноцтой аюул учруулах нөхцөл үүсэж болзошгүй гэж өөрсдөө үзсэн ажилтнуудыг ажил үүрэг гүйцэтгэхээс татгалзах боломж олгох, түүнчлэн үг ажлыг хийснээр гарах үр дагавраас хамгаалах явдлыг хангасан зохицуулалт**

Ажилтан бүр төвийн ерөнхий үйл явц, түүний дотор өөрийн харьяалагдах алба, тасгийн үйл явц, орц, гарц, харилцан уялдаа, эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага, түүнийг хэрэгжүүлэхэд хувь хүн, алба, тасгийн оруулах хувь нэмэр, дагаж мөрдөөгүйгээс гарах үр дагавар, ХЭМАБ-ын аюул, эрсдэл, сэргийлэх арга хэмжээ, ямар тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхээс татгалзах боломжтой зэрэг мэдлэгийг сайн ойлгож мэдсэн байна.

Эдгээр мэдлэгийг шинэ ажилтны чиглүүлэх сургалт, нийт ажилтны менежментийн тогтолцооны болон ХЭМАБ-ын сургалт, алба, тасгийн дагалдан сургах хөтөлбөрөөр тус тус олгодог.

ЦССҮТ нь нийт ажилтандаа дараах зүйлсийг мэдээлж, ойлгуулна. Үүнд:

7.3.1. ЦССҮТ-ийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс

7.3.2. Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого, зорилт

7.3.3. Нэгдсэн менежментийн тогтолцооны гарын авлага, холбогдох журам зааврууд

7.3.4. Нэгдсэн менежментийн тогтолцоонд оруулсан хувь нэмэр

7.3.5. Нэгдсэн менежментийн тогтолцооны шаардлага хангаагүйгээс гарах үр дагавар ба үршиг

7.3.6. Төвийн хэмжээнд тодорхойлогдсон аюултай тохиолдлууд, эрсдэл, эрсдлээс сэргийлэх арга хэмжээнүүд

7.3.7. Амь нас ба эрүүл мэндэд нь зайлшгүй ба ноцтой аюул учруулах нөхцөл үүсэж болзошгүй гэж өөрсдөө үзсэн ажилтнуудыг ажил үүрэг гүйцэтгэхээс татгалзах боломжтойг.

#### 7.4 Мэдээлэл харилцаа

**Байгууллага нь нэгдсэн менежментийн тогтолцоонд хамаарах дотоод болон гадаад харилцаанд шаардлагатай үйл явцуудыг бий болгох, хэрэгжүүлэх, хэвийн ажиллуулах ба дараах асуудлуудыг хамруулна.**

##### **а/ Юу мэдээлэх**

##### **б/ Хэзээ мэдээлэх**

##### **с/ Хэнд мэдээлэх**

##### **д/ Хэрхэн мэдээлэх**

##### **е/ Хэн мэдээлэх**

ЦССҮТ нь нэгдсэн менежментийн тогтолцоонд холбогдолтой мэдээллээр дотоод болон гадаад орчинд дараах байдлаар харилцдаг. Үүнд:

Мэдээллийн дотоод орчинд:

- Даваа гариг бүрийн дунд шатны менежерүүдийн шуурхай зөвлөгөөнөөр өнгөрсөн 7 хоногт хийсэн ажил, нэмэлт мэдээллийн талаар мэдээлэл солилцох ба алба, тасгийн дарга, эрхлэгч нар шуурхай зөвлөгөөний мэдээллийг хамт олондоо мэдээлэх
- Бүх ажилчдын хурлыг жилд 1-2 удаа зохион байгуулж, хийсэн ажлын тайлан, цаашид хэрэгжүүлэх ажлын зорилтыг мэдээлэх
- Тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдэл, үл тохирол илэрвэл илрүүлсэн ажилтан илрүүлсэн тэр даруйдаа алба, тасгийн эрхлэгчид, шаардлагатай бол чанарын албаны дарга, төвийн захиралд нууцлалын зэргээс хамаарч амаар, утсаар мэдээлэх
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой ноцтой аюул, эрсдэл илэрвэл илрүүлсэн ажилтан илрүүлсэн тэр даруйдаа алба, тасгийн эрхлэгчид, шаардлагатай бол ХАБ хариуцсан ажилтан, төвийн захиралд амаар, утсаар мэдээлэх

Бусад холбогдох мэдээллийг төвийн хаалттай цахим хуудас, хурал, шуурхай, самбар дээрхи мэдээлэл, албаны тэмдэглэл, эрсдэл мэдээлэх хуудсаар зэрэг олон хэлбэрээр мэдээлэх ба мэдээлэл дамжуулах гол зорилго үйл ажиллагааг зөв явуулах, үүсэх эрсдэл, аюулыг урьдчилан тогтоож, бүртгэж мэдээлэн засах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх явдал юм.

Мэдээллийн гадаад орчинд:

- Төвийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг сонирхогч талуудад төвийн “Цус сэлбэлт судлалын үндэсний төв” пэйж хуудас, [www.donor.mohs.mn](http://www.donor.mohs.mn) вэб хуудсаар дамжуулан хариуцсан ажилтнууд цаг үеийн мэдээ, мэдээллийг мэдээлэх
- Тусламж үйлчилгээтэй болон хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой гарсан сөрөг мэдээллийн хариуг төвийн Ерөнхий захирал хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд нээлттэй мэдээлэх



## 7.5 Баримтжуулсан мэдээлэл

### 7.5.1. Ерөнхий зүйл

**Нэгдсэн менежментийн тогтолцоонд дараах мэдээлэл багтана. Үүнд:**

**а/ Энэхүү олон улсын стандартад шаардсан баримтжуулсан мэдээлэл**

**б/ Нэгдсэн менежментийн тогтолцооны үр нөлөөг хангахад шаардлагатай гэж байгууллагаас тодорхойлсон баримтжуулсан мэдээлэл**

ЦССҮТ-ийн нэгдсэн менежментийн тогтолцооны баримтжуулсан мэдээлэлд дараах мэдээлэл багтах ба баримтжуулсан мэдээллийг 4 ангилна. Үүнд:

Баталж мөрдөх мэдээлэл:

- Эрхэм зорилго, алсын хараа, Нэгдсэн менежментийн тогтолцооны гарын авлага, Үйл явцын тодорхойлолт, журам, САЗ, АЗ, ТТАЗ, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан,

Тодорхойлж хадгалах мэдээлэл:

- Хууль, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын албан даалгавар, Төрийн албаны зөвлөлийн зөвлөмж, стандарт, Эрүүл мэндийн сайдын тушаал, төвийн Ерөнхий захирлын тушаал

Хөтөлж хадгалах мэдээлэл:

- Маягт

Бүртгэн нотлох мэдээлэл:

- Хяналтын хуудас, аудитын тайлан, зөвлөмж, үл тохирлын бүртгэл, засч сайжруулсан арга хэмжээ, санал хүсэлтийн дүн, түүний мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- ЦССҮТ-ийн баримт бичгийн мастер лист

### 7.5.2. Мэдээлэл бий болгох, шинэчлэх

**Баримтжуулсан мэдээллийг бий болгож шинэчлэхдээ байгууллага нь:**

**а/ товъёог ба тодорхойлолт**

**б/ хэлбэр ба тээгч**

**с/ тохиромж ба зохистой байдлын хяналт ба албажуулалтыг түс түс зохимжтой байдлаар хангана.**

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

ЦССҮТ нь баримтжуулсан мэдээлэл боловсруулах журмыг мөрдөж ажиллах ба баримт бичгийн бүтэц, агуулагдахууныг тодорхойлсон жишиг загвар боловсруулж, төвийн хэмжээнд жигд мөрддөг. Үүнд:

- a) Баримт бичгийн тэмдэглэгээ, тайлбар /нэр, зохиогч, огноо, дугаар гэх мэт/
- b) Хэлбэр / боловсруулах хэл, програм хангамжийн хувилбар, график, зөөгч цаасан цахим /
- c) Баримт бичиг тухайн ажилбар, түвшинд тохирч, зохистой байгаад дүн шинжилгээ хийж баталгаажуулдаг.

Төвийн хэмжээнд мөрдөх, хөтлөх баримтжуулсан мэдээлэл нь мөрдөж байгаа стандартын шаардлагад нийцсэн **нэг стандарт загвартай** байна.

Алба, тасгийн удирдлага өөрийн хамааралтай үйл явц, ажилбарт 1, 2, 3, 4-р түвшний хэдэн баримтжуулсан мэдээлэл байхыг тодорхойлж түүнийг бүрдүүлж, боловсруулан батлуулж, эмч, мэргэжилтэн, ажиллагсдыг сургаж, мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай өөрчлөлт шинэчлэлт хийж, хянах үүрэг гүйцэтгэдэг.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Баримт бичиг боловсруулах, дугаарлах, кодлох, архивлах журам

### **7.5.3. Баримтжуулсан мэдээллийг хянах**

#### **7.5.3.1 Нэгдсэн менежментийн тогтолцоо болон энэхүү стандартад шаардсан баримтжуулсан мэдээллийг:**

**а/ Шаардлагатай үед, шаардлагатай газар, хүртээмжтэй болон тохиромжтой хэлбэрээр байгаа эсэх**

**б/ зохих хэмжээнд хамгаалагдсан эсэх (нууц алдагдах, буруугаар ашиглах, бүрэн бүтэн байдал алдагдах зэргээс)-ийг тус тус хангаж байгааг нотлохын тулд хянана.**

Нэгдсэн менежментийн тогтолцоо стандартын дагуу төвд байвал зохих баримтжуулсан мэдээлэл баримт бичгийг дараах зорилгоор хянаж байна. Үүнд:

- a) Алба, тасаг, нэгжийн ажлын байр бүр дээр үйл явц, ажилбар хийхэд мөрдөх холбогдох баримт бичиг хүртээмжтэй, тохиромжтой хэлбэрээр байгаа эсэх,
- b) Зохих хэмжээнд нууцлал, буруугаар ашиглагдахаас, бүрэн бүтэн байдал, алдагдахаас сэргийлэгдсэн эсэх, ажлын байр дээр хүчин төгөлдөр, сүүлийн зөв хувилбар ашиглаж байгаа эхэсийг тус тус хянана.

Баримтжуулсан мэдээлэл баримт бичгийг ажлын байр бүр дээр тохиромжтой хэлбэрээр түгээж баримтжуулахыг алба, тасгийн эрхлэгч, ажлын байран дээр ашиглах, бүрэн бүтэн байлгах, хадгалах, буруугаар ашиглах, нууц алдагдахаас хамгаалах үүргийг тухайн ажлын байран дээр ажиллаж байгаа эмч, мэргэжилтэн, ажиллагсад тус тус хариуцна.

Төвийн чанарын алба, ХЭМАБ-ын зөвлөл холбогдох, албаны дарга, тасгийн эрхлэгчтэй хамтран жилд 1-ээс доошгүй удаа баримт бичгийн хяналтыг хийнэ.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Баримт бичиг хянах журам

**7.5.3.2 Баримтжуулсан мэдээллийг хянахын тулд байгууллага дараах арга хэмжээнд анхаарал тавина. Үүнд:**

**а) түгээх, нэвтрэх, сэргээх, ашиглах**

**б) хадгалах, хамгаалах, тухайлбал гаргацтай байдлыг хамгаалах**

**с) өөрчлөлтийг хянах**

**д) архивлах ба устгах**

**Нэгдсэн менежментийн тогтолцооны төлөвлөлт, хэрэгжүүлэлтэнд шаардлагатай гадны эх үүсвэр бүхий баримтжуулсан мэдээллийг байгууллага зохих хэмжээнд ялгаж, хянана. Тохирлын нотолгоо болгон хадгалж байгаа баримтжуулсан мэдээллийг санамсаргүйгээр өөрчлөхөөс хамгаална.**

Баримтжуулсан мэдээллийг хянахын тулд байгууллага дараах арга хэмжээнд анхаарал тавина. Үүнд:

- а) Хүчин төгөлдөр баримт бичгийг түгээлт, ашиглалт
- б) Ажлын байран дээр зөв хадгалах, аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах, гаргацтай байдал
- с) Өөрчлөлтийг хянах, хамгийн сүүлийн засвар хийж өөрчилсөн хувилбарыг ашиглаж байгаа байдал, жил бүр хянасан эсэх
- д) Хүчингүй болсон баримт бичгийн нэг хувийг архивлах, бусад хувийг устгасан /хүн ашиглах боломжгүй болгосон байх/ байдал, баримтжуулалт хийсэн байдал

Төвийн менежментийн тогтолцооны төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд шаардлагатай **гадны эх үүсвэр бүхий** баримтжуулсан мэдээллийг ялгаж, дугаарлан хянан баримтжуулна.

Баримт бичигт эрх бүхий албаны дарга, тасгийн эрхлэгч, холбогдох мэргэжлийн эмч, мэргэжилтэн завсар хийж протокол хөтлөн баримтжуулан, чанарын албаар баталгаажуулна.

Чанарын алба төвийн хэмжээний бүх баримтжуулсан мэдээллийн мастер жагсаалтыг бүртгэн, нэгтгэж, төвийн захирлаар баталгаажуулна.

Алба, тасаг баталгаажсан, хүчинтэй, шинэчилсэн баримт бичгийн хувилбарыг цахимаар түгээж баримтжуулалт хөтөлнө. Мөн албаны дарга, тасгийн эрхлэгч нар баталгаажсан хүчин төгөлдөр баримт бичгийн 2-р хувилбарыг сканердэн ЭШМТА-д хүргүүлж, цахимд байршуулан эмч, мэргэжилтэн, ажиллагсад авч ашиглах боломж бүрдүүлэн ашиглах сургалт зохион байгуулж, аюулгүй байдал, нууцлал, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Ажлын байран дээр мөрдөж ашиглах баримт бичгийг хадгалах хамгаалах хариуцлагыг эмч, мэргэжилтэн, ажиллагсад хариуцуулж баримтжуулна. 7 хоног, сар, улирлаар ажлын байр солигдон хуваарилагдахад баримт бичиг хүлээлцэж баримтжуулна.

Алба, тасаг хуучин баримт бичгийг хураан авч, бүртгэн, устган баримтжуулна.

Чанарын алба дээр хадгалж байсан баримт бичгийн 1-р албан хувийг архивт өгч баримтжуулна.

## **8. Ажиллагаа**

### **8.1 Ажиллагааны төлөвлөлт ба хяналт**

**Байгууллага нь бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэхэд шаардлагатай болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны үйл явцуудыг төлөвлөж, бий болгож, хэрэгжүүлж, хянах ба дараах арга хэмжээнүүдийг авна. Үүнд:**

**а/ бүтээгдэхүүн, үйлчилгээний болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны шаардлага/шалгуур/-ыг тодорхойлох**

**б/ Бүтээгдэхүүн, үйлчилгээний болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцоонд шалгуур тогтоох, хяналт хийх**

**с/Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлагыг хангахад хэрэгцээтэй нөөцийг тодорхойлох**

**д/ Ажлыг ажилтанд тааруулах**

**е/ Баримтжуулсан мэдээллийг шаардлагын хэмжээнд мөрдөж ба хөтөлж хадгалах**

**Байгууллага нь төлөвлөсөн өөрчлөлтүүдийг хянах, санамсаргүй өөрчлөлтүүдийн үр дагаварт дүн шинжилгээ хийх, сөрөг нөлөөг аль болох бууруулах арга хэмжээг авна. Байгууллага нь гаднаас авч гүйцэтгүүлж байгаа үйл явцуудыг хяналтанд байлгана.**

ЦССҮТ-ийн үндсэн үйл ажиллагаа нь цус цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, түгээх явдал бол дэмжих үйл ажиллагаа нь багаж хэрэгслийн халдваргүйжүүлэлт, угаалга, цэвэрлэгээ, тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ, бараа материал ханган нийлүүлэх, нөөц бүрдүүлэх, санхүү нягтлан бодох бүртгэл, үйл ажиллагааны тоон мэдээ цуглуулж, тайлан мэдээ гаргах, боловсруулалт хийх, эмч, мэргэжилтнийг сургах, мэргэшүүлэх, судалгаа шинжилгээний ажил эрхлэх, стратеги төлөвлөлт, нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлж, хөгжүүлэх, сайжруулах болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох явдал юм.

Эдгээр үйл ажиллагааны шаардлага, үйл явцын хяналт, үүсч болох эрсдэл, сөрөг үр дагаврын нөлөөлөл, нөөц зэргийг тодорхойлсон ба алба, тасгууд баримтжуулсан мэдээллийг шаардлагын хэмжээнд тодорхойлж, хадгалдаг.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Төвийн үндсэн ба дэмжих үйл ажиллагааны үйл явцууд
- Үйл явцын хяналт хийх бүртгэл

#### **8.1.2. Аюулыг арилгах ба ХЭМАБ-ын эрсдлийг бууруулах**

**Байгууллага нь дараах шаталсан хяналтыг хэрэглэх замаар аюулыг арилгах ба ХЭМАБ-ын эрсдлийг бууруулахын тулд үйл явцуудыг бий болгох, нэвтрүүлэх ба хэрэгжүүлнэ.**

##### **а/ Аюулыг арилгах**

**б/ Аюул багатай түүхий эд, үйл явцууд, ажиллагаа эсвэл тоног төхөрөөмжөөр орлуулах**

**с/инженерингийн хяналт ашиглах/ эсвэл ажлыг өөрчлөн зохион байгуулах**

**д/ Захиргааны хяналт хэрэгжүүлэх, үүнд сургалт хамаарна.**

**е/ Тохиромжтой хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах**

ЦССҮТ нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулах, аюулыг арилгах, эрсдлийг бууруулах эсвэл хянахын тулд дараах аргуудаар хангахыг зоридог.

а/ Аюулыг арилгах:

- аюулыг зайлуулах
- аюултай химийн бодис хэрэглэхийг зогсоох

б/ Орлуулах

- Аюултайг аюул багатайгаар солих
- ХЭМАБ-ын эрсдэлтэй эх үүсвэрийг байхгүй болгохын төлөө ажиллах

с/ Инженерингийн хяналт:

- Уян хатан ажлын цагийн хуваарилалт
- Явуулын хэрэгслийг урьдчилан зөөх шийдэл
- Явуулын ор хэрэглэх

д/ Захиргааны хяналт:

- Аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Тоног төхөөрөмжийн үзлэг
- Ажлын байрны үзлэг
- Ханган нийлүүлэгч байгууллагын тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалт
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт
- Анхны тусламжийн сургалт
- Эрүүл амьдралын хэвшил, зөв хооллолтын сургалт

е/ Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл: Зохистой нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах

- Ажлын хувцас (өмд, цамц, халад, зузаан цамц, куртка)

- Нэг удаагийн бээлий
- Резинэн бээлий
- Зузаан бээлий
- Нэг удаагийн халад
- Нэг удаагийн малгай
- Хулдаасан хормогч
- Усны гутал
- хамгаалалтын гутал
- Нүдний шил

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- ХЭМАБ-ын аюул эрсдлийг тодорхойлох, зохицуулах журам

### 8.1.3 Өөрчлөлтийн менежмент

**ХЭМАБ-ын үйл ажиллагааг сайжруулахад үр дүнтэй нөлөөлөхүйц, богино хугацааны болон үрт хугацааны өөрчлөлтүүдийг байгууллага хэрэгжүүлж, хянах үйл явцуудыг бий болгоно. Үүнд дараах зүйлс орно:**

**а/ Шинэ эсвэл өөрчлөлт орсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцууд орно. Үүнд:**

- **Ажиллах нөхцөл**
- **Ажлын байрны байрлал ба хүрээлэл**
- **Тоног төхөөрөмж**
- **Ажиллах хүчин**

**б/ Хууль тогтоомжийн шаардлага ба бусад шаардлагад орсон өөрчлөлтүүд**

**с/ Аюул ба ХЭМАБ-ын эрсдлийн талаарх мэдээлэл эсвэл мэдлэгийн өөрчлөлтүүд**

**д/ Мэдлэг ба технологийн хөгжил**

ЦССҮТ нь ХЭМАБ-ын үйл ажиллагааг сайжруулахад үр нөлөөтэй байхуйц дараах өөрчлөлтүүдийг хэрэгжүүлсэн.

- Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шинжилгээний хэсгийн иж бүрэн засвар хийсэн.
- Төвийн 1-р байрны вакуум цонхнуудыг сайжруулсан.
- ЦЦБ цуглуулах, үйлдвэрлэлийн хаалттай систем нэвтрүүлсэн.
- Гамшгийн үеийн нөөцийн өрөөг шинээр байгуулсан.
- ХЭМАБ-ын зөвлөлийг шинээр байгуулж, үүрэг хариуцлагыг тодорхойлсон.
- Аюулгүй ажиллагааны зааврыг алба, тасгийн дарга эрхлэгч нар өгч хэвшсэн.
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг дээд удирдлагын болон нийт ажиллагсдын түвшинд зохион байгуулж, гэрчилгээжүүлсэн.
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын сертификаттай сургалтанд 2 ажилтныг хамруулж, гэрчилгээжүүлсэн.
- QR-аар аюулыг мэдээлэх боломжийг бүрдүүлж, ажилтнуудыг сургасан.

### 8.1.4 Худалдан авалт

#### **8.1.4.1. Ерөнхий зүйл**

**Байгууллага нь бүтээгдэхүүн ба үйлчилгээний худалдан авалт ХЭМАБ-ын менежментийн тогтолцоотой нийцэж байгааг хянах үйл явцуудыг бий болгох, хэрэгжүүлэх ба хэвийн ажиллуулна.**

Байгууллагын худалдан авалтыг хийхдээ ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны тохирлыг хангах шаардлагуудыг тодорхойлж, удирдлагын бус ажилтнуудтай зөвлөлдөхийг чухалчилдаг.

Ханган нийлүүлэгч байгууллагаас нийлүүлсэн эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа:

а/ Тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг байгуулж, ажиллагааг туршдаг

б/ ханган нийлүүлэгч байгууллагын мэргэжлийн инженерийн удирдлага дор, тоноглолуудыг туршиж, ажлын байрны сургалт хийдэг

с/ Бараа, материалын техникийн тодорхойлолттой тулгадаг

д/ Тоног төхөөрөмжийн танилцуулга, ажиллуулах гарын авлага, аюулгүй ажиллагааны зааврыг Монгол хэл дээр орчуулуулж хүлээн авдаг.

#### **8.1.4.2 Гэрээлэгчид**

ЦССҮТ нь хамтран ажиллагч, ханган нийлүүлэгчдийн гэрээнд ХЭМАБ-ын шаардлагыг тусгасан. Гэрээний:

9 дүгээр заалт. “Нийлүүлэгчийн мэргэжилтэн, ажилтан нь нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээтэй холбоотой, ачаалах, тээвэрлэх, хадгалах, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын /ХЭМАБ/-ын шаардлагыг бүрэн хангах үүрэгтэй”.

10 дугаар заалт. “Бараа бүтээгдэхүүн ачаалах, тээвэрлэх, хадгалах асуудлаар захиалагч нь нийлүүлэгч байгууллага түүний мэргэжилтэн, ажилтны өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй ”

#### **8.1.4.3 Бусдаар гүйцэтгүүлэх**

ЦССҮТ-ийн бусдаар гүйцэтгүүлэх чиг үүрэгт харуул хамгаалалтын үйлчилгээ, донорт хүнсээр үйлчлэх үйлчилгээ орох бөгөөд энэхүү үйл ажиллагааны үйл явцыг тодорхойлж, хяналт тавьдаг.

#### **8.2 Онцгой байдлын бэлэн байдал ба хариу арга хэмжээ**

ЦССҮТ нь олж тогтоосон онцгой байдалд бэлдэх, хариу арга хэмжээ авах үйл явцуудыг бий болгож нэвтрүүлж, хэрэгжүүлнэ. Үүнд:

а/ Гамшгийн эрсдлийн үнэлгээнд үндэслэн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан харьяа газрын онцгой байдлын хэлтсээр хянуулж, батлуулсан. /МУ-ын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар батлагдсан зааврыг мөрдлөг болгосон./

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

b/ Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт мэргэжлийн баг, ажилчдын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор онцгой байдлын дадлага сургуулилтыг тодорхой хугацаанд давтамжтайгаар хийдэг.

c/ Онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө ба хариу арга хэмжээний Тохиолдлын удирдлагын тогтолцооны баг ажилладаг.

d/ Нийт ажилчдын сургалтаар онцгой байдлын бэлэн байдлын үед ажиллах үүрэг, хариуцлагын талаар мэдлэг олгосон.

e/ Онцгой байдал үүссэн үед ажиллах мэргэжлийн багийн гишүүдийг энэ чиглэлийн сургалтанд хамруулан, мэдлэг ур чадвартай болгож бэлтгэсэн

f/ Онцгой байдлын үеийн аврах гарц, цугларах цэг болон холбогдох мэдээллийг зочид, гэрээтүүдэд тогтмол мэдээлдэг

g/ Холбогдох сонирхогч талуудын чадвар ба хэрэгцээнд үндэслэн хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулдаг.

## **8.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлага**

### **8.2.1 Хэрэглэгчтэй харилцах**

#### **Хэрэглэгчтэй харилцах харилцаанд:**

**a/ Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллээр хангах**

**b/ Лавлагаа гаргах, гэрээ буюу захиалга, өөрчлөлтийг мэдэгдэх**

**c/ Бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчийн санал хүсэлт (гомдол)-ийг авах**

**d/ Хэрэглэгчийн өмчтэй харьцах эсвэл хяналтанд байлгах**

**e/ Гэнэтийн тохиолдолд, шаардлагатай бол, авах арга хэмжээний түсгэй шаардлагыг тогтоох зэргийг хамруулна.**

ЦССҮТ нь хэрэглэгчтэй харилцах харилцаанд:

a/ Цус цусан бүтээгдэхүүн хэрэглэгч гэрээт эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд ЭМС-ын 2017 оны А/03, 2020 оны А/373 дугаар тушаал, багц цагийн сургалт, хэвлэмэл материал болон гарын авлагаар, Цусны доноруудад төвийн вэб сайт, пэйж хуудас, пэйж хуудасны чат бот хэсэг, мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр холбогдох мэдээллийг түгээдэг.

b/ Цус, цусан бүтээгдэхүүн нийлүүлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад лавлагаа авах, гаргах, гэрээ байгуулах, гэрээ, захиалганд өөрчлөлт гарвал мэдэгдэнэ. Хэрхэн хэзээ, хэн мэдэгдэх тухай журам, САЗ-д тодорхой тусгаж өгнө. Цус, цусан бүтээгдэхүүн нийлүүлэх талаар харилцагч эмнэлгүүдтэй, донорын сургалт, сурталчилгаа хийх сайн дурын ажилтан бэлтгэх талаар МУЗН, ДШУЗХ-той, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх талаар ханган нийлүүлэгчтэй гэрээ байгуулж, үр дүнг үнэлж ажиллана.



с/ Үйлчлүүлэгчдээс ирүүлсэн санал хүсэлт (гомдол)-ийг хүлээн авах ажлыг олон талт хэлбэрээр зохион байгуулж, хариу арга хэмжээ зохион байгуулдаг.

д/ Төвөөс тусламж, үйлчилгээ авч байгаа бүх үйлчлүүлэгчийн өмчтэй зөв харьцан, хянаж хамгаалдаг. Тухайлбал, хувийн мэдээлэл, шинжилгээний хариу, хувцасны өлгүүр, цоожтой хайрцаг, автомашины зогсоол, харуул хамгаалалтын ажилтан, хяналтын камер зэрэг

е/ Тусламж үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчид сөрөг хариу урвал илэрсэн үед үзүүлэх анхны тусламжийн бэлэн байдал хангагдсан.

## **8.2.2 Бүтээгдэхүүн үйлчилгээний шаардлагыг тодорхойлох**

**Хэрэглэгчдэд санал болгох гэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхойлох тохиолдолд:**

**а/ Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих дараах шаардлагыг тогтоосон:**

**1/Холбогдох хуулийн ба зохицуулалтын аливаа шаардлага**

**2/ Байгууллагаас хэрэгтэй гэж үзсэн шаардлага**

**б/ Байгууллага өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх гаргаж байгаа шаардлагад тохирсон байх нөхцлийг хангана.**

а/ ЦССҮТ-ийн бүтээгдэхүүн үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхойлохдоо:

- Монгол улсын “Донорын тухай” хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаал, шийдвэр, ЦЦБ-д тавигдах чанарын болон техникийн шаардлага, MNS ISO 9001:2016 стандартын шаардлага;
- Тусламж үйлчилгээнд нэвтэрсэн шинэ техник, технологитой уялдуулан ЦЦБ-ийг рентген туяагаар шарах, эмгэгтөрөгчийг идэвхигүйжүүлэх зэрэг нэмэлт шаардлагуудыг хамруулдаг.

б/ Төв нь өөрийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг шийдвэрлэдэг.

## **8.2.3. Бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаарах шаардлагыг хянаж үзэх**

**8.2.3.1 Байгууллага нь хэрэглэгчдэд санал болгож байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагыг хангах чадвартай байх нөхцлийг хангана.**

ЦССҮТ нь бүтээгдэхүүн, үйлчилгээндээ холбогдох хуулийн, чанарын болон техникийн стандартын шаардлагыг хангах чадвартай байх нөхцлийг хангаж, үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүн, тусламж үйлчилгээг хэрэглэгчид нийлүүлэх шийдвэр гаргахаас өмнө дараах шаардлагуудыг хянаж үзнэ. Үүнд:

- Цус, цусан бүтээгдэхүүн захиалах, хүлээн авах болон тээвэрлэж аваачсаны дараа зөв харьцах, хадгалах, гэсгээх, сэлбэх талаарх шаардлага

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

- Өвөрмөц бүтээгдэхүүнд тавигдах шаардлага (ЯЭӨ, Нэгтгэж савласан криопреципитат)
- ЦЦБ-ий захиалга өгөх, хүлээн авах, бүтээгдэхүүн тээвэрлэх, хадгалах нөхцөл
- ЭМС-ын 2020 оны А/373, 2017 оны А/03 тушаалаар батлагдсан тусламж үйлчилгээтэй холбоотой шаардлага
- Захиалга тодорхой бус эсвэл өвөрмөц үед захиалагчтай заавал холбогдож, тодруулга авна.

**8.2.3.2 Байгууллага нь баримтжуулсан мэдээллийг: хянаж үзсэн үр дүн, бүтээгдэхүүн, үйлчилгээний аливаа шинэ шаардлагатай холбогдуулан хадгалж эрх мэдэлдээ байлгана.**

ЦССҮТ нь ЦЦБ-ийг хорионоос чөлөөлж, эмнэлэгт олгохдоо дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална. Үүнд:

- ЦЦБ-ий шаардлагыг хянаж, хийгдсэн халдвар илрүүлэх, бүлэг тодорхойлох, чанарын хяналтын шинжилгээний баталгаажсан үр дүнг хянаж, шаардлагад нийцсэн тохиолдолд хорионоос чөлөөлөх
- ЦЦБ-ий аливаа шинэ шаардлага (туяагаар шарах, эмгэгтөрүүлэгчийг идэвхигүйжүүлэх, нэгтгэн болон жижиглэн савлах)-тай холбогдсон баримтжуулсан мэдээллийг тус тус хөтөлж хадгална.

**8.2.4. Бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагад орсон өөрчлөлт**

**Байгууллага нь бүтээгдэхүүн үйлчилгээний шаардлага өөрчлөгдсөн бол баримтжуулсан мэдээллийг өөрчилж, холбогдох ажилтныг энэ тухай мэдээллээр хангана.**

ЦССҮТ-ийн баримт бичигт өөрчлөлт оруулах бол холбогдох ажилтан өөрчлөлтийг тусган боловсруулж, алба, тасгийн эрхлэгч, цусны чанар, аюулгүй байдлын албаны даргаар хянуулан, Ерөнхий захирлаар батлуулдаг.

Өөрчлөлт орсон тухай мэдээллийг баримт бичгийн мастер листэд тусган шинэчилж, холбогдох эмч, мэргэжилтэн, ажилтнуудад сургалт хийн танилцуулж, баримт бичигтэй танилцсан бүртгэл хөтлөн, хэрэгжилтэнд албаны дарга, тасгийн эрхлэгч нар хяналт тавьж ажилладаг.

**8.3 Бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн ба боловсруулалт**

**8.3.1 Ерөнхий зүйл**

**Байгууллага нь бүтээгдэхүүн, үйлчилгээнд дагалдах үйлчилгээг хангасан дизайн гаргах болон боловсруулах үйл явцыг бий болгож, хэрэгжүүлж мөрдөнө.**

ЦССҮТ нь ЦЦБ, тусламж үйлчилгээнд дагалдах үйлчилгээг хангасан шинэ бүтээгдэхүүн, арга аргачлал боловсруулахад дизайн гаргах болон үйл явцыг бий болгож, хэрэгжүүлж мөрдөнө. Төв үйлдвэрлэж буй цус, цусан бүтээгдэхүүн, үйлчлүүлэгчид үзүүлж буй тусламж, үйлчилгээг олон улсын сайн туршлага, эмнэлгийн техник, технологийн дэвшилтэд тулгуурлан шинэ арга, аргачлал боловсруулах, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх дизайн боловсруулна.

**8.3.2 Дизайн ба боловсруулалтыг төлөвлөх**

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

ЦССҮТ нь шинэ бүтээгдэхүүний дизайн, боловсруулалтын үе шатыг тодорхойлж, хянахын тулд дараах баримтжуулсан мэдээллийг авч үзнэ. Үүнд:

a/ Бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, холбогдох хууль, стандарт, журмын шаардлагад нийцүүлэн сайжруулж, шинэчлэн боловсруулах учир шалтгаан, энэ өөрчлөлт, сайжруулалтыг хийхэд зарцуулах хугацаа, учирч болох бэрхшээл

b/ Шаардлагатай үйл явц, үе шатуудыг тодорхойлсон САЗ, ТТАЗ

c/ Шалгаж, баталгаажуулах үйл ажиллагаа

d/ Хамаарах хариуцлага, эрх мэдэл

e/ Шаардлагатай гадаад болон дотоод нөөц

f/ Ажилтнуудын улдаа, холбоог хянах хэрэгцээ

g/ Хэрэглэгч, үйлчлүүлэгчдийг дизайн гаргах, боловсруулах үйл явцад оролцуулах хэрэгцээ

h/ Дагалдах үйлчилгээнд тавих шаардлага

i/ Дизайн гаргах боловсруулах явцад хэрэглэгч, бусад сонирхогч талаар хийлгэх хяналтын түвшин

j/ Шаардлага хангасныг нотлох баримтжуулсан мэдээлэл зэрэг багтана. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний боловсруулалтын үе шат бүрийг бүрэн баримтжуулж хадгална.

### **8.3.3 Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын оролтууд**

ЦССҮТ нь шинэ бүтээгдэхүүний дизайн гаргах, боловсруулах гэж буй онцлог төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаарах зайлшгүй шаардлагыг тодорхойлно. Үүнд:

a/ Чиг үүргийн болон гүйцэтгэлийн шаардлага

b/ Өмнө нь хийж байсан ижил төстэй дизайн боловсруулалтын талаарх мэдээлэл

c/ хууль тогтоомжийн шаардлага

d/ Төвийн мөрдөх стандарт ба зохистой дадлын дүрэм

e/ Бүтээгдэхүүн, үйлчилгээний мөн чанараас хамааран гарах магадлалтай гологдол

дизайн боловсруулалтын орц нь хангалттай, иж бүрэн, давхардаагүй байх ба зөрчилтэй орцыг шийдвэрлэнэ. Баримтжуулсан мэдээллийг хадгална.

### **8.3.4 Дизайн боловсруулалтын хяналт**

ЦССҮТ нь шинэ бүтээгдэхүүн боловсруулах дизайн гаргах, боловсруулах үйл явцын талаар дараах баримтжуулсан мэдээллийг хадгалж, хянана. Шинэ бүтээгдэхүүн гарахдаа эцсийн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт ямар байх, шат дамжлагын хяналтын эгзэгтэй цэгүүдийг тодорхойлж, шалган хянаж, баримтжуулсан байна. Мөн шинэ

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

бүтээгдэхүүний үйлдвэрлэх арга, технологи, ашиглах тоног төхөөрөмж, хэрэглэх хүүдий, уусмал, чанарын хяналт хийх шинжилгээний арга бүгд баталгаажсан байна. Баталгаажуулалт хийх САЗ –ыг мөрдөн хянаж, үр дүнг баримтжуулсан байна. Шинэ бүтээгдэхүүн боловсруулахад дараах үйл явцын хяналт хийн баримтжуулна. Үүнд:

- a) Шинэ дизайн гаргаж боловсруулснаар хүрэх гэж буй үр дүнг тогтоох
- b) Шинэ дизайн боловсруулалтын үр дүн шаардлага хангах чадвартайг үнэлэх зорилгоор хянаж, үзэх
- c) Дизайн боловсруулалтын гарц нь орцын шаардлагыг хангасныг нотлох зорилгоор шалгалтын үйл ажиллагаа явуулсныг
- d) Эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зориулалтын болон тодорхой хэрэглээний шаардлагыг хангаж байгааг тодорхойлохын тул баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулсныг
- e) Хянаж үзэх, шалгах, баталгаажуулах явцад гарсан аливаа асуудлыг шийдвэрлэх
- f) Эдгээр арга хэмжээний талаарх баримтжуулсан мэдээллийг хадгалж, эрх мэдэлдээ байлгах нөхцөлийг хангах зорилгоор хянана.

### **8.3.5 Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын гаралт**

ЦССҮТ нь шинэ бүтээгдэхүүний дизайн, боловсруулалт хийх үйл явцын гаралтын талаар дараах баримтжуулсан мэдээллийг хадгалж, хянана. Үүнд:

- a) Орцын шаардлагыг хангасан байдлыг нотлох
- b) Бүтээгдэхүүн, үйлчилгээний дагалдах үйлчилгээнд тохирсон байх
- c) Байнгын хяналт, хэмжилтийн тохиромжтой шаардлага болон хүлээж авах шалгуурыг тусгах буюу иш татах, Шинэ бүтээгдэхүүний шинж чанарыг тодорхойлж, зөвшөөрөх хэмжээг тогтоосон байна.
- d) Бүтээгдэхүүн, үйлчилгээний зориулалтанд нийцэх, зөв аюулгүй байдалд нэн чухал үзүүлэлтийг тогтоох зэрэг хамаарна.

### **8.3.6 Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын өөрчлөлт**

ЦССҮТ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагын тохиролд сөрөг нөлөөгүй байдлыг хангах хэр хэмжээнд, шинэ бүтээгдэхүүний дизайн боловсруулалт хийх явцад эсвэл дараа нь гарсан өөрчлөлтийг тогтоож, дүн шинжилгээ хийж, хянана. Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад ямар шинэ хэрэгсэл уусмал орох, энэ нь чанар хангасан байх, үе шат дамжлагад өөрчлөлт орсон байдлыг үнэлнэ.

ЦССҮТ дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. Үүнд:

- a) Дизайн, боловсруулалт хийх үйл явцын өөрчлөлт
- b) Хяналтын дүн шинжилгээний үр дүн
- c) Өөрчлөлт хийх зөвшөөрөл төвийн удирдлага, чанарын албанаас зөвшөөрөл авч хадгална.
- d) Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлсэн арга хэмжээ зэрэг хамаарна. Хадгалалт, тээвэрлэлт болон бусад зүйлд нэмэлтээр орсон өөрчлөлтийг хөтөлж хадгална.

## **8.4 Гаднаас авч буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт**

### **8.4.1 Ерөнхий зүйл**

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

ЦССҮТ нь гаднаас авч буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлно. Гаднаас авч байгаа бүтээгдэхүүнд импортоор болон хандив тусламжаар авч байгаа цус бүлэгнэлтийн 8, 9-р факторууд, альбумин, иммуноглобулин зэрэг орно. Төв гаднаас авч буй бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээнд тавих хяналтыг дараах тохиолдолд тодорхойлно. Үүнд:

- a) Гаднаас авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээг төвийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй нэгтгэх бол
- b) Хэрэглэгчид шууд хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээг гадны нийлүүлэгч байгууллагын нэрийн өмнөөс хийж байгаа тохиолдолд
- c) Үйл явц болон түүний хэсгийг байгууллагын шийдвэрийн дагуу гадны нийлүүлэгч гүйцэтгэж байгаа тохиолдолд тус тус хянана.

Гадны нийлүүлэгчийн шаардлагын дагуу үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээг хангах чадварт үндэслэн гүйцэтгэлийг үнэлэх, сонгох, хянах, дахин үнэлэх шалгуурыг ЦССҮТ тодорхойлж хэрэглэнэ. Төв эдгээр үйл ажиллагаа болон үнэлгээний дүнгийн дагуу хийсэн шаардлагатай арга хэмжээний талаарх баримтжуулсан мэдээллийг хадгална.

Худалдан авах гэрээнд ямар шаардлага тавихыг тодорхой тусгаж баримтжуулна. Бүтээгдэхүүний цуврал бүрийн чанарын сертификат чухал ач холбогдолтой. Хэрэглээний дараа эмчилгээний үр дүн ямар байгааг эмч нараас цуглуулан хянаж, хадгална.

ЦССҮТ -ийн гадны нийлүүлэгчид цусны донор, ханган нийлүүлэгч байгууллага орно.

#### **8.4.2 Хяналтын төрөл ба хэмжээ**

ЦССҮТ гаднаас авч буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь өөрийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд тууштай хүргэх чадварт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангана. Төвийн чанарын болон техникийн стандартад гадны бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхой тусгаж өгнө.

ЦССҮТ дараах арга хэмжээг авна. Үүнд:

- a) Гаднаас нийлүүлж байгаа үйл явц, цусны донорууд болон ханган нийлүүлэгч нь чанарын менежментийн тогтолцооны хяналтад байлгана.
- b) Цусны донор, ханган нийлүүлэгч байгууллага болон түүний гаргаж байгаа гаралтын аль алинд нь зориулсан хяналтыг тогтооно
- c) Дараах асуудалд анхаарна. Үүнд:
  1. Бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэгчийн болон хууль тогтоомжийн шаардлагыг тууштай хангах талаарх байгууллагын чадварт гаднаас нийлүүлж байгаа үйл явцад үзүүлэх боломжит нөлөөлөл,
  2. Гадны нийлүүлэгчдийн хэрэглэж байгаа хяналтын үр нөлөөтэй байдлыг тус тус анхаарна.
- d) Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлага хангаж байгааг нотлох шалгалт буюу бусад үйл ажиллагааг тодорхойлох асуудлыг тус тус шийдвэрлэнэ.

Гаднаас нийлүүлж буй үйлчилгээ, бүтээгдэхүүний эцсийн хариуцлагыг ЦССҮТ хариуцна. Иймд гаднаас нийлүүлж цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хэрэглэж байгаа цусны хүүдий, оношлуур, кит бусад бүх хэрэгслийн чанарын баталгааг бүрэн авч хянана. Тухайлбал үйлдвэрлэгчийн олон улсын чанарын сертификат, бүтээгдэхүүний

цуврал бүрийн чанарын сертификат, холбогдох хяналтын байгууллагын шинжилгээний үр дүн, шийдвэр гэх мэт

#### **8.4.3 Гадны нийлүүлэгчдэд зориулсан мэдээлэл**

ЦССҮТ гадны нийлүүлэгч болох донор, ханган нийлүүлэгчидтэй холбогдохоос өмнө тавих гэж байгаа шаардлага тохиромжтой байх нөхцөлийг хангана. Төв дараах шаардлагыг гадны нийлүүлэгчид мэдээлнэ. Үүнд:

- a) Нийлүүлэх үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар
- b) Мөн доорх зүйлийг батлах тухай үүнд:
  1. Бүтээгдэхүүн, үйлчилгээ
  2. Арга, үйл явц, тоног төхөөрөмж
  3. Бүтээгдэхүүн гаргах, үйлчилгээ үзүүлэхийг батлах
- c) Ажилтнуудын чадамж, түүний мэргэшсэн байдал
- d) Гадны нийлүүлэгчтэй төв харилцах харилцаа ямар бүтээгдэхүүн үйлчилгээ авах урьд байсныг хэрхэн сайжруулж байгааг ойлгуулах төвөөс гадны нийлүүлэгчид үзүүлэх үйлчилгээ
- e) Гадны нийлүүлэгчийн гүйцэтгэлийг төвөөс хянах мониторинг хийх – нийлүүлэлт хэрхэн хийгдэж байгаа хугацаа, бүтээгдэхүүний чанар, нийлүүлэх үйлчилгээ хир зэрэг байгааг үнэлэх
- f) Гадны нийлүүлэгчийн байранд төвөөс эсвэл тэдний хэрэглэгчийн зүгээс хийх шалгалт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд хамаарах шаардлагыг гадны нийлүүлэгчид тус тус мэдээлнэ.

Тухайлбал: Цусны хүүдийн хэдэн төрөл тэдгээр нь ямар өвөрмөц шаардлага хангасан байхыг төв эхлэн зөв тодорхой, нарийн тусгаж тендерийн материалд тусгасан байна. Эдгээр өвөрмөц шаардлагууд ханган нийлүүлэгчид ойлгомжтой байх хэрэгтэй.

#### **8.5 Үйлдвэрлэл явуулах ба үйлчилгээ үзүүлэх**

##### **8.5.1 Үйлдвэрлэл явуулах, үйлчилгээ үзүүлэх ажлын хяналт**

ЦССҮТ нь ЦЦБ-ний үйлдвэрлэл, тусламж, үйлчилгээг хяналттай нөхцөлд гүйцэтгэнэ. Хяналттай нөхцөлд дараах зүйлсээс аль тохирохыг нь хамааруулна. Үүнд:

- a) Дараах баримтжуулсан мэдээллийг бэлэн байлгана. Үүнд
  1. Үйлдвэрлэх гэж байгаа бүтээгдэхүүн, үзүүлэх гэж буй тусламж, үйлчилгээ, гүйцэтгэх гэж буй ажлын үзүүлэлтүүд. Төв цусан бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээний үзүүлэлтийг тодорхойлж хийх хяналтыг САЗ-д тусган мөрдөнө.
  2. Хүрэх үр дүнгийн талаар - бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээний чанарыг тодорхой үзүүлэлтээр хянасан бол 4-р шатны маягт хөтөлж баримтжуулна.
- b) Хяналт хэмжилтийн зохих нөхцөлийг бэлэн байлгах, ашиглах тухайлбал термометрээр тээвэрлэлтийн хэмийг, оношлуурын чанарыг стандарт загвараар тус тус хянаж болно.
- c) Гаралтын явцыг хянах шалгуур болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээн авах шалгууруудыг хангаж байгааг үйл ажиллагааны холбогдох үе шатуудад байнгын хяналт, хэмжилтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар шалгах – чанарын хяналт, рН метр, баталгаажилтийн калибровка хийх зэргээр

- d) Үйл явцыг хэрэгжүүлэхэд тохиромжтой дэд бүтэц ба орчныг ашиглах- чийгшил, температур, жижиг биенцэрийн тоо гэх мэт
- e) Шаардлагатай мэргэшил бүхий ур чадвартай ажилтныг томилох, ур чадвартай ажилтныг сонгох нь чухал
- f) Байнгын хяналт, хэмжилтийн аргаар гаралтыг нь шалгах боломжгүй үйлдвэрлэл болон үйлчилгээний үйл явцууд нь төлөөлсөн үр дүнд хүрэх чадварыг баталгаажуулах, тодорхой давтамжтайгаар дахин баталгаажуулах – Тоног төхөөрөмжийг тодорхой давтамжаар баталгаажуулна. Үйлчилгээг хэмжих хэцүү зөвхөн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжаар хэмжиж болно.
- g) Эмч, мэргэжилтэн, ажиллагсдыг алдаа гаргахаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх- тасралтгүй сургалтыг зохион байгуулах нь их чухал. Алдаа, үл тохирлыг хэзээ ч нууж болохгүй нэн даруй шат дараалан мэдээлж, засч, сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ойлголтыг ажилтан бүрд сургалтаар өгч, мөрдүүлж, ажиллах. Өөрийн болон бусдын үйл ажиллагаанд давхар хяналт хийх ач холбогдлыг мэдүүлэх нь онцгой ач холбогдолтой.
- h) Боловсруулж, бэлэн болгох нийлүүлэх болон нийлүүлэлтийн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

### **8.5.2 Тэмдэглэгээ ба мөшгөх боломж**

ЦССҮТ нь төвийн хэмжээнд мөрдөж байгаа болон олон улсын стандартын шаардлагад бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын байдлыг илэрхийлэхэд шаардлагатай гаралтуудыг тодорхойлох үйл явцын аргыг хэрэглэнэ. Үйл ажиллагаанд цахим бүртгэл, сүлжээ системийг бүрэн нэвтрүүлж ажиллана.

Үйлдвэрлэл явуулах болон үйлчилгээ үзүүлэх явцад хийгдэж байгаа хяналт, хэмжилтийн шаардлагад хамаарах гаралтуудын байдлыг тодорхойлно.

Мөшгөх боломжтой байхыг шаардсан тохиолдолд байгууллага гаралтын өвөрмөц тэмдэглэгээг хийж, мөшгөх боломжийг хангахад шаардлагатай баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. Тухайлбал: ЦЦБ эмнэлэгт олгохдоо халдвар илрүүлэх болон бүлэг тодорхойлох шинжилгээ хийгдэн зөв хариу гарсан тохиолдолд бүтээгдэхүүнийг эмнэлэгт олгоно. Давхар хяналт баримтжуулалт хийгдсэн байна. Донороос цус авахуулаад цусан бүтээгдэхүүнийг эмнэлэгт олгох хүртэлх бүр үйл явц, ажилбар бүрэн баримтжуулагдан бүтээгдэхүүн бүр дахин давтагдахгүй дугаараар дугаарлагдсан байна. Баримтжуулалтын тогтолцоо зөв нэвтэрч, хөгжсөн тохиолдолд ямар ч нөхцөлд мөшгөн тогтоох боломж бүрдсэн байна.

### **8.5.3 Хэрэглэгч болон гадны нийлүүлэгчийн өмч**

ЦССҮТ өөрийн хяналтанд байгаа эсвэл ашиглаж байгаа хэрэглэгчийн болон гадны нийлүүлэгчийн өмчийг хамгаална.

ЦССҮТ нь хэрэглэгчийн болон гадны нийлүүлэгчийн өмчийг өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглах эсвэл нэгтгэх гэж байгаа бол түүнийг тэмэглэж, шалгаж, хамгаалах ба хөнөөлөөс сэргийлнэ.

Хэрэглэгч болон гадны нийлүүлэгчийн өмч алдагдах, гэмтэх эсвэл ашиглах боломжгүй болгоход хүргэсэн бол байгууллага энэ тухай хэрэглэгч буюу гадны нийлүүлэгчид мэдээлж, болсон явдлын тухай баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Цусны донор, эмнэлгийн эмч, мэргэжилтэн, өвчтөн, лавлагаа шинжилгээ хийлгүүлж байгаа үйлчлүүлэгч иргэд гадны нийлүүлэгч, хэрэглэгч болно. Тухайлбал донороос цус, сийвэн авахын өмнө арьс ариутгах үйл ажиллагаа арга ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлбэл нийлүүлэгчийн эрүүл мэнд алдагдана. Иймд бид үүнээс сэргийлж ажилна.

Цусны донорын эрүүл мэндийн асуудал хэрэглэгчийн өмчид хамаарна. ЦССҮТ нь эрүүл мэндийн байгууллагын учир үйлчлүүлэгчийн хувийн болон эрүүл мэндтэй холбоотой мэдээллүүдийн нууцлалыг хамгаалах үүрэг, хариуцлага хүлээж ажиллана. Эдгээр мэдээллийг цусны аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор төвийн эмч, мэргэжилтэн ашиглаж болно. Төвийн эмч, тусгай мэргэжилтэн, мэдээллийн технологийн ажилтан бүр төвийн үйл ажиллагаатай холбоотой бүх мэдээллийн нууцлалыг хангаж, хамгаалж алдагдахаас сэргийлж ажиллах “Нууцлалын гэрээ” байгуулсан байна. Энэ гэрээний асуудлыг төвийн нууцлалын ажилтан ба хүний нөөцийн мэргэжилтэн хариуцаж, холбогдох баримтжуулалт, шинэчлэлт, өөрчлөлт, баталгаажуулалтыг хийнэ. Донорын хувийн болон эрүүл мэндийн мэдээллийг өөр зорилгоор ашиглах болон нууцлалыг алдагдуулвал холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээнэ.

Донор зохион байгууллалтын тасгийн эмч, сувилагч, нийгмийн болон олон нийттэй харилцах мэргэжилтнүүд цусны донорын хувийн болон эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг авах, бүртгэх, шинэчлэх эрх, үүрэгтэй ба эдгээр мэдээллийн нууцлалыг чанд хадгалах хариуцлагыг давхар хүлээнэ. Мэдээллийг оруулсан, шинэчилсэн, зассан зэрэг хийгдсэн бүх зүйлийг зөв, бүрэн баримтжуулж, мөшгөн тогтоох нөхцөлүүд бүрдүүлж ажиллана.

Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч донорын хувийн болон эрүүл мэндтэй холбоотой бүх мэдээллийг бүртгэх, шинэчлэх, хадгалах, нууцлалыг чанд хадгалах ажиллагааг тасгийн үйл явцын тодорхойлолт, журам, САЗ, АЗ –д тодорхой тусган, хариуцах эмч, ажилтанг маш тодорхой тусган үүрэгжүүлж, ямар ч тохиолдолд мөшгөн тогтоох нөхцөл бүрдүүлсэн байх тогтолцоог хэрэгжүүлж, хянаж, байнга сайжруулж ажиллана.

Төвийн Лаборатори, Технологи, Мэдээллийн технологи, инженер техникийн тасгийн эмч, тусгай мэргэжилтэн, ажилтнууд цусны донорын шинжилгээний үзүүлэлт, шинжилгээний үр дүн, цахим сүлжээн дэх мэдээллийг бүртгэх, шалгах, шинэчлэх, шаардлагатай үед засвар оруулах үйл ажиллагааг МТИТ-ийн цахимд ажиллах журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй. Дээрхи үйл ажиллагаа бүрийг бүрэн, зөв баримтжуулсан байна.

Төвийн бусад эмч, мэргэжилтнүүд ажлын шаардлагаар цахим сүлжээнээс нэмэлт мэдээлэл авах ажиллагааг төвийн нууцлалын журмаар зохицуулна. Судалгаа шинжилгээний ажилд шаардагдах мэдээлэл олгохыг төвийн захирал зөвшөөрөл олгох ба албаны дарга, тасгийн эрхлэгч нар холбогдох эмч, мэргэжилтнүүдэд мэдээлж, баримтжуулалт хөтлүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

Донор зохион байгуулалтын тасгийн болон төвийн их эмч нар цусны донор цус, сийвэн, эс өгөхөд эрүүл мэндийн талаас шалгуур үзүүлэлтэд тохирч, нийцсэн, эдгээр донороос бэлтгэсэн цусан бүтээгдэхүүн эмчлүүлэгчийн эрүүл мэндэд сөрөг нөлөө



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

үзүүлэхгүй нотолгоог эмчийн үзлэг, ярилцлага, лабораторийн шинжилгээний үр дүнгээр нотолж, донорын эрүүл мэндийн картанд бичэглэл хийн баримтжуулсан байна. Их эмч үзлэгийн явцад донорт эрүүл аж төрөх ёс, дадал хэвшлийн талаар тогтмол зөвлөгөө өгч ажиллана. Шаардлагатай үед эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө, үзлэг, шинжилгээнд илгээн үр дүнг авч хянаж баталгаажуулж ажиллана. ДЗБТ-ийн эмч, нийгмийн ажилтан цусны доноруудад эрүүл аж төрөх ёс, эрүүл амьдралын дадал, хэвшил олгох, эрүүл мэндээ хамгаалах сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.

Хэрэглэгч, нийлүүлэгчээс байнга санал хүсэлт авч үнэлж, үйл ажиллагаа, үйлчилгээний орчноо сайжруулах хэрэгтэй.

#### **8.5.4 Бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгаалах**

ЦССҮТ нь бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах, үйлчилгээ үзүүлж байх явцад шаардлагын тохирлыг хангах хэмжээнд үйл явцын гаралтуудыг хамгаална. Хамгаалах гэдэгт таних, тэмдэглэгээ хийх, харьцах, бохирдлыг хянах, баглах, хадгалах, шилжүүлэх, дамжуулах, тээвэрлэх, хамгаалах асуудал хамааруулж үзнэ.

ЦССҮТ нь стандартын шаардлагад нийцсэн цус, сийвэн эс, цуглуулах, шинжлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, эмнэлэгт олгох үйл ажиллагааг явуулна.

#### **8.5.5 Нийлүүлэлтийн дараах үйл ажиллагаа**

ЦССҮТ бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээнд хамаарах нийлүүлсний дараах шаардлагыг хангана. Цусны донорууд цус, сийвэн, эс өгсний дараах болон ЦЦБ-ийг эмнэлэгт олгосны дараа, бүтээгдэхүүнийг эмчилгээнд сэлбэсний дараах үйл ажиллагаа ЦССҮТ-д хамаарна. Тухайлбал: Улаан эсийн бүтээгдэхүүнийг сэлбэх үед бүлэн үүссэн тохиолдолд хэрхэн мэдээлж, цусны алба ямар арга хэмжээ авах зэрэг асуудлууд хамаарна.

Нийлүүлэлтийн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээг тодорхойлохын тулд төв дараах зүйлийг авч үзнэ. Үүнд:

- a) Хууль тогтоомж, туушаалаар зохицуулсан шаардлага
- b) Бүтээгдэхүүн үйлчилгээнд хамаарах боломжит тааламжгүй болзошгүй тааламжгүй үр дагаврууд – тухайлбал үйлчлүүлэгч нойтон шалан дээр хальтирч унах эрсдэл үүнээс сэргийлж сэрэмжлүүлэх тэмдэглэл тавьж хэвших
- c) Бүтээгдэхүүн, үйлчилгээний мөн чанар, хэрэглээ, ашиглалтын хугацаа – тухайлбал бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа
- d) Хэрэглэгчийн шаардлага
- e) Хэрэглэгчийн санал хүсэлт

Нийлүүлэлтийн дараах үйлчилгээнд баталгааны нөхцөлийн агуух арга хэмжээ, засвар үйлчилгээ гэх мэт гэрээний нэмэлт үүрэг, дахин ашиглах эсвэл устгал хийх зэрэг нэмэлт үйлчилгээ тус тус багтаж болно.

ЦЦБ олгохдоо технологич эмч, сувилагч нар тээвэрлэлт, эмнэлэг дэх хадгалалт, өвчтөнд сэлбэлт хийх үед анхаарах зөвлөмжийг амаар, дүрс бичлэг, зөвлөмж, гарын авлага хэлбэрээр өгнө.

## ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Мөн ЦЦБ нийлүүлэх гэрээнд тээвэрлэлт, хадгалалт, сэлбэх үед ЦЦБ- тэй зөв харьцах, зөв ажиллагаа, хийгдэх хяналт, үнэлгээний талаар тусгаж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

ЭМ-ийн сайдын 2020 оны 373 тоот болон 2017 оны 03 тоот тушаалаар батлагдсан заавар журмыг мөрдөж ажиллана.

### **8.5.6 Өөрчлөлтийн хяналт**

ЦССҮТ үйлдвэрлэл явуулах буюу үйлчилгээ үзүүлэх явц дахь өөрчлөлтүүд нь шаардлагад нийцсээр байгааг бататгах хяналт, дүн шинжилгээг хэрэгжүүлнэ.

Төвийн үйл явц, ажиллагаанд ямар нэг өөрчлөлт хийх шаардлагатай үед төвийн алба, тасгийн эмч, мэргэжилтэн ажиллагсад санал, үндэслэл гарган холбогдох эмч, мэргэжилтэнд танилцуулна. Санал, хүлээж авсан эмч, ажилтан үндэслэлийг шалган, үндсэн болон бусад дэмжих үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг судлан туршилт, давхар хяналт хийж баримтжуулна. Өөрчлөлт, давхар хяналтын нотолгоо үр дүнгийн хамт тасгийн эрхлэгч, албаны даргад танилцуулна.

Тасгийн эрхлэгч, албаны дарга хамт олноор хэлэлцүүлэн хяналт, нотолгооны үр дүнд тулгуурлан үйл явц, бусад үйл ажиллагааны нөлөөллийг судлан өөрчлөлтийг зөвшөөрч, холбогдох баримт бичгүүдэд /журам, САЗ, ТТАЗ, АЗ, ХХ, маягт/ нэмэлт өөрчлөлт хийн шинэчлэн чанарын албанд төслийг хүргүүлнэ.

Төвийн албаны дарга, тасгийн эрхлэгч, холбогдох мэргэжилтний нотолгоо, үр дүнгийн судлагаа, зөвшөөрлийн дагуу чанарын албаны дарга хянаж зөвшөөрөл олгоно.

Төвийн ерөнхий захирал дээрхи зөвшөөрөл, хяналтын дүнг үндэслэн баталгаажуулалт хийн гарын үсэг зурж, тамгалснаар үйл ажиллагаанд хэрэгжих эцсийн хяналт, баталгаажилт хүчин төгөлдөр болно.

Төв эдгээр өөрчлөлтөд хийсэн дүн шинжилгээний үр дүн, өөрчлөлт хийх эрх бүхий албаны дарга, тасгийн эрхлэгч, чанарын албаны ажилтны мэдээлэл, дүн шинжилгээний дагуу авсан арга хэмжээнүүдийн талаарх баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

### **8.6 Бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргаж, бэлтгэх**

ЦССҮТ нь бүтээгдэхүүн, үйлчилгээ нь шаардлага хангаж байгааг шалгах төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг холбогдох үе шатанд хэрэгжүүлнэ.

Цус цуглуулахаас эхлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинжлэх, хадгалах тээвэрлэх, эмнэлэгт олгох зэрэг бүх үйл явцын үе шат бүрийн ХЭЦ-ийг хянаж, үр дүнг баримтжуулан давхар шалгалт хийсэн байна.

Төлөвлөсөн арга хэмжээ хангалттай хэрэгжиж дуусах, холбогдох эрх бүхий байгууллагаас болон ашиглаж болохыг хэрэглэгч зөвшөөрөх хүртэл бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид гаргаж, нийлүүлэхгүй байна.

ЦССҮТ бүтээгдэхүүн үйлчилгээг гаргаж, нийлүүлэхтэй холбоотой баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. Баримтжуулсан мэдээлэлд дараах асуудлыг тусгана. Үүнд:

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

- a) Хүлээн авах шалгуурыг хангаж байгаа тухай нотолгоо – шат дамжлага бүрийн хяналт, баталгаажуулалт хийгдсэн байна.
- b) Бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах эрх мэдэл бүхий ажилтны тодорхойлолт зэргийг тусгасан байна. Үйлдвэрлэсэн ЦЦБ-ийг эмчилгээнд олгох зөвшөөрлийг Технологийн тасгийн эрхлэгч, технологич эмч нар, үйлдвэрлэлийн явцын хяналт, баримт нотолгоо, НЛ-ийн тасгийн халдвар илрүүлэх, цусны бүлэг тодорхойлох болон чанарын хяналтын шинжилгээний үр дүнд үндэслэн олгож баримтжуулна. Технологийн тасгийн бүтээгдэхүүний нөөц хариуцсан тойролт дээр ажиллаж байгаа технологич сувилагч ЦЦБ-ийг хорионоос чөлөөлж, эмнэлэгт олгох бүтээгдэхүүний ялган ангилалт, давхар хяналт, бүх баримтжуулалт бүрдүүлэлтийг хянаж, нотолгоо бүрдүүлж ажиллана.

## 8.7 Үл тохирол бүхий гаралтын хяналт

**8.7.1** ЦССҮТ нь шаардлагад тохирохгүй байгаа гаралтыг санамсаргүй байдлаар хэрэглэх, хэрэглэгчид хүргэхээс сэргийлж, тэмдэглэгээ хийж хянана.

Төв үл тохирлын мөн чанар болон түүний бүтээгдэхүүн, үйлчилгээнд үзүүлэх үр нөлөөнд тохирох арга хэмжээ авна. Үүнийг бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлсний дараа, үйлчилгээ үзүүлж байх үед, эсвэл үзүүлсний дараа, үл тохирох байдлыг олж тогтоосон үед мөн хэрэгжүүлнэ.

ЦССҮТ-ийн бүх ажилчид шат дамжлагын хяналт хийн шаардлага хангасан үед дараагийн үе шатанд шилжүүлж, баримтжуулалт хөтөлнө.

Зөвшөөрөх хязгаараас хэтэрсэн тохиолдолд асуудал шийдэгдтэл хорионд хадгалж, таних тусгаарлах тэмдэглэл хийнэ. Хэн шалгасан гэдгийг эмч, мэргэжилтний дахин давтагдахгүй дугаараар тогтооно. Тасгийн эрхлэгч нар дахин давтагдахгүй дугаарыг олгож, баримтжуулан чанарын албанд мэдээлнэ. Чанарын алба төвийн үндсэн үйл ажиллагааны бүх тасгийн ажилчдын дугаар, бүртгэлийг хадгална. Ажилтан солигдох, шинэ ажилтан орох үед шинэчлэн баталгаажуулна.

Төв үл тохирол бүхий гаралтыг авч үзэхдээ дараах арга замуудын аль нэг эсвэл хэд хэдийг ашиглана.

- a) Залруулга
- b) Тусгаарлах, битүүмжлэх, буцаах буюу бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлтийг зогсоох
- c) Хэрэглэгчид мэдээлэх
- d) Тохиролцсоны үндсэн дээр хүлээн авахыг зөвшөөрүүлэх /Хүлээн зөвшөөрөх хязгаарт байгаа үед, хариу гараагүй үед олгох онцгой тохиолдолд/

Үл тохирол бүхий гаралтыг залруулсны дараа тохирлыг нотолно.

**8.7.2** ЦССҮТ дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. Үүнд:

- a) Үл тохирлын тухай тайлбар
- b) Авсан арга хэмжээний тухай тайлбар
- c) Тохиролцсон тухай тайлбар
- d) Үл тохирлын талаар шийдвэр гаргах эрх мэдэл бүхий этгээдийг тодорхойлох

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Төв үл тохирлын үед авах хэмжээний журам боловсруулж мөрдөнө. Техник ажиллагаа, тоног төхөөрөмж, бичиг хэргийн, дүгнэлт буруу гаргах зэрэг үл тохирол байж болно. Үл тохирлыг хэрхэн илрүүлэх, хэнд мэдээлэх, хэрхэн засах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх талаар журамд тусгасан байна.

## 9. Гүйцэтгэлийн үнэлгээ

### 9.1 Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ

#### 9.1.1 Ерөнхий зүйл

ЦССҮТ нь ЦЦБ үйлдвэрлэн эмнэлгийн байгууллагад нийлүүлэх үндсэн болон дэмжих үйл ажиллагаатай холбоотой дараах зүйлсийг 7 хоног бүр шуурхай зөвлөгөөн дээр мэдээлэл сонсож, хэлэлцэнэ. Үүнд:

- а) Цусны донорын сургалт сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд хамт олонтой хамтран хийсэн үр дүн, үүнээс цус цуглуулах үйл ажиллагаанд хамрагдсан байдал,  
Цус, сийвэн эс, цуглуулсан удаа, хэмжээ, цуглуулалтын үеийн хаягдал, ТТ тасагт хүлээлгэн өгсөн цус, сийвэн, эсийн хэмжээ, НЛ-ийн тасагт хүлээлгэн өгсөн шинжилгээний тоо  
Шинжилгээнд хүлээн авсан сорьцын тоо, чанар, шинжилсэн шинжилгээний нэр төрөл, үр дүн халдварын эерэг хувь, давтан шинжлсэн удаа, орон нутгаас ирүүлсэн сорьцын тоо, хариу баталгаажилт, ЦЦБ-ний дээжинд хийсэн чанарын хяналтын шинжлгээний төрөл, үр дүн Шинжлгээний дотод болог гадаад үнэлгээний үр дүн  
Үйлдвэрлэсэн ЦЦБ төрөл хэмжээ, захиралга, олголт нөөцийн мэдээ бүтээгдэхүүн, бүлэг тус бүрээр алсын тээвэрлэлт, онцгой болон их хэмжээний захилга, олголт  
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, үйлчилгээ, засвар, цахим сүлжээний ажиллагаа, цахилгааны хэвийн ажиллагаа, авсан арга хэмжээ  
Урт богино хугацааны сургалт, хамрагдсан хүн, хүний нөөцийн шилжих хөдөлгөөн гадаад хамтын ажиллагааны гол мэдээ  
СТСБ, ЧМ, ХЭМАБ-ын тогтолцооны талаар хийсэн гол үйл ажиллагаа, анхаарах асуудлыг товч мэдээлэл сонсож ажиллана
- б) 7 хоногийн шуурхай дээр дээрх үйл ажиллагааны гол мэдээ, товч үр дүн, мэдээллийг сар, улирлаар үйл ажиллагааны болон тоон төлөвлөгөөний дэлгэрэнгүй тайланг сонсож ерөнхий захирал шийдвэр гаргаж ажиллана.
- в) Дээрхи үйл ажиллагаанд алба, тасаг нэгжийн удирдлага тогтмол хяналт тавьж үр дүнг үнэлж ажиллана. Шаардлагатай үед төвийн захиралд мэдэгдэж холбогдох шийдвэр гаргуулан арга хэмжээ авч ажиллана. Мониторинг, хэмжилтийг гүйцэтгэх хугацааг үйл ажиллагаатай холбоотой
- д) Жилийн эцэст төвийн алба, тасаг, эмч, мэргэжилтэн бүрийн ажлын гүйцэтгэл, тайланг сонсож, үнэлж дүгнэж ажиллана.

ЦССҮТ нэгдсэн менежментийн тогтолцооны гүйцэтгэл болон үр нөлөөг үнэлнэ. Төв үнэлгээний үр дүнд холбогдох баримтжуулсан мэдээллийг нотолгоо болгон хөтөлж, хадгална.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

ЦССҮТ төвийн эмч, мэргэжилтэн, ажиллагсдын ур чадвар, үйл ажиллагаанд хэрэглэж байгаа арга, аргачлал, тоног төхөөрөмжийн ажиллагаанд мониторинг, хяналт, хэмжилт, үнэлгээ хийж, баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

Төвийн алба, тасгууд үйл ажиллагааны гол тоо баримтуудыг өдөр бүр цуглуулж, 7 хоног, сар, улирл, хагас бүтэн жилээр нэгтгэн үнэлж ажиллана. Үндсэн үйл ажиллагааны гол тоо мэдээний тайланг архивт өгч хадгалуулна.

### **9.1.2 Хэрэглэгчийн сэтгэл ханамж**

ЦССҮТ нь хэрэглэгчийн хэрэгцээ ба найдлага хэр хэмжээнд хангагдаж байгаа тухай тэдний ойлголтын талаар хянан магадлана. Төв нь дээрх мэдээллийг олж авах, мониторинг, дүн шинжилгээ хийх аргыг өөрийн үйл ажиллагааны өвөрмөц онцлогт тохируулан тодорхойлно.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, санал хүсэлт, хэрэглэгчидтэй хийх уулзалт, зах зээл маркетингийн судалгаа сэтгэгдэл, баталгааны шаардлага, бүтээгдэхүүн олголтын тайлан орно.

Төвийн алба, тасаг бүр үйлчүүлэгч, хэрэглэгч, хамтран харилцан холбоотой ажилладаг байгууллага, тасаг, иргэдээс сар бүр тодорхой тооны санал хүсэлтийг олон арга хэлбэрээр авч, нэгтгэн дүгнэж, санал хүсэлтийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, үр дүнг тооцон алба, тасаг, хамт олонд ил тод мэдээлж ажиллана.

Төвийн ёс зүйн хороо эмч, мэргэжилтнүүдээс ЭМ-ийн сайдын тушаалд заасны дагуу санал хүсэлтийг авч, үнэлэн үр дүнг төвийн удирдлагад танилцуулан санал хүсэлтийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлж, үр дүнг хамт олонд мэдээлж ажиллана.

Сэтгэл ханамжийг үнэлэхэд бэрхшээлтэй. Хүн бүр адилгүй, өөр өнцгөөс харж өөр өөр үнэлгээгээр үнэлдэг учир ирсэн санал хүсэлт бүрийг хамт олноор хэлэлцэн үйл ажиллагааг сайжруулах өнцгөөс харж шийдвэрлэхэд анхаарах хэрэгтэй.

### **9.1.3 Шинжилгээ ба үнэлгээ**

ЦССҮТ нь мониторинг, хэмжилтийн үр дүнгээс гарах холбогдох өгөгдөл ба мэдээллийг шинжилж, үнэлнэ. Шинжилгээний үр дүнг дараах үнэлгээнд ашиглана. Үүнд:

- a) ЦЦБүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээний стандартын болон холбогдох шаардлагад нийцсэн тохирлын байдал
- b) Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинийн өөрчлөлт
- c) Нэгдсэн менежментийн тогтолцооны гүйцэтгэл ба үр нөлөөг сайжруулах боломж
- d) Үйл ажиллагааг тасалдалгүй хэвийн зохион байгуулах, ЧМТийг хөгжүүлэх төлөвлөлтийн хэрэгжилт, гүйцэтгэл, үр нөлөөг сайжруулалт
- e) Эрсдэл болон боломжийг авч үзсэн арга хэмжээний үр нөлөөтэй байдал
- f) Гадны нийлүүлэгчийн гүйцэтгэл - хүүдий, оношлуурын нийлүүлэлт, үнэлгээ, баталгаажуулалт, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, баталгаажуулалт
- g) Нэгдсэн менежментийн тогтолцоог сайжруулах хэрэгцээг тодорхойлох зэрэг болно.

Төв үндсэн болон дэмжих үйл ажиллагааны гол үзүүлэлт бүрийн тоо мэдээ баримтыг сар бүр цуглуулан нэгтгэн дүн шинжилгээ, статистик боловсруулалт хийнэ.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Нэгдсэн менежментийн тогтолцооны баримтжуулалт хэр хэрэгжиж үр дүнгээ өгч байгаа, төлөвлөгдсөн үйл ажиллагаа хэрхэн чанартай цаг хугацаандаа хэрэгжиж байгаа, цаашид сайжруулах ямар гарц, арга зам байгааг дүгнэн хэлэлцэж төвийн захирал шаардлагатай өөрчлөлт хийх шийдвэр гаргаж ажиллана.

## 9.2 Дотоод аудит

**9.2.1** ЦССҮТ нь нэгдсэн менежментийн тогтолцооны талаар дараах мэдээллийг авахын тулд дотоод аудитыг төлөвлөсөн хугацаанд хийнэ.

- а) Доорх шаардлагад тохирч байгаа тухай:
  - 1. Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны байгууллагын өөрийн шаардлага
  - 2. Олон улсын энэхүү стандартын шаардлага
- б) Үр нөлөөтэй хэрэгжиж, хэвийн ажиллаж байгаа тухай

Төв өөрийн үйл ажиллагаанд хийгдэх дотоод аудитын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, аудитын баг томилж, аудитын маягтын дагуу үнэлгээг хийнэ.

### 9.2.2 Байгууллага нь:

- а) Холбогдох үйл явцуудын ач холбогдол, байгууллагад нөлөөлж буй өөрчлөлтүүд, өмнөх аудитын үр дүнд үндэслэн аудитын давтамж, аргачлал, хариуцлага, төлөвлөх шаардлага, тайлагнал зэргийг тусгасан аудитын хөтөлбөрийг төлөвлөж бий болгох ба хэрэгжүүлж, мөрдөж, хадгална.
- б) Аудит тус бүрийн шалгуур, хамрах хүрээг тогтооно
- с) Аудитын үйл явц нь бодитой, шударга байхуйцаар аудиторыг сонгож, аудитыг явуулна.
- д) Аудитын үр дүнг холбогдох удирдлагад мэдээлнэ
- е) Зохих залруулга болон залруулах арга хэмжээг хойшлуулалгүй авна
- ф) Аудитын хөтөлбөр хэрэгжсэн тухай болон аудитын үр дүнгийн нотолгоо болох баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- ЦССҮТ-ийн жилийн аудитын хөтөлбөр

Аудитыг ISO 9001:2015, 45001:2018 стандартын бүх шалгуурын дагуу жилд 1-ээс доошгүй удаа хийнэ. Жилийн турш бүх алба, тасагт стандартын бүлэг бүрээр хэрэгжилтийг үнэлсэн байна.

Аудитыг хийх төлөвлөгөө, маягтыг боловсруулан төвийн захирлаар батлуулна. Аудит хийх эмч, мэргэжилтнүүдийг сургана. Хөндлөнгийн тасгийн хүмүүсээр хийлгэнэ. Аудитын үр дүн, зөвлөмжийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг хамтран боловсруулна. Зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянаж үзнэ.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Аудитын тайлан, зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө

### **9.3 Удирдлагын дүн шинжилгээ**

#### **9.3.1 Ерөнхий зүйл**

Төвийн Ерөнхий захирал төвийн нэгдсэн менежментийн тогтолцоо байгууллагын алсын хараа эрхэм зорилго, стратегийн чиг хандлагад тохирсон, нийцсэн, үр нөлөөтэй, байнга хэрэглэх байдалд нь дүн шинжилгээг жилийн эцэст 1 удаа хийнэ. Удирдлагын зөвлөлөөр юуг хэрхэн яаж сайжруулах талаар хэлэлцэнэ. Удирдлагын дүн шинжилгээ хийх журмыг мөрдөж ажиллана.

#### **9.3.2 Удирдлагын дүн шинжилгээний оролтууд**

Удирдлагын дүн шинжилгээг төлөвлөсөн байх ба дараах асуудлыг авч үзнэ. Үүнд:

- a) Өмнөх удирдлагын дүн шинжилгээний дагуу авсан арга хэмжээний тухай анх удаа хийж байгаа бол энэ асуудал хамаарахгүй.
- b) Нэгдсэн менежментийн тогтолцоонд хамаарах гадаад, дотоод асуудлуудад гарсан өөрчлөлтүүд
- c) Нэгдсэн менежментийн тогтолцооны болон ЭМ-ийн лабораторийн чанар ба чадахид тавигдах шаардлага стандартын гүйцэтгэл ба үр нөлөөний мэдээлэлд дараах чиглэлийг хамааруулна. /Үйл ажиллагааны статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ/ Үүнд:
  1. Холбогдох сонирхогч талуудаас ирсэн санал, хүсэлт болон хэрэглэгчийн сэтгэл ханамж
  2. Чанарын зорилтууд биелсэн байдал, хэр хэмжээ
  3. Үйл явцын гүйцэтгэл ба бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын байдал
  4. Үл тохирлууд ба залруулах арга хэмжээнүүд
  5. Байнгын хяналт, мониторинг, хэмжилтийн үр дүн
  6. Аудитын үр дүнгүүд
  7. Гадны нийлүүлэгчдийн гүйцэтгэлийг харуулсан чанарын менежментийн тогтолцооны хандлагыг харуулсан гүйцэтгэлийн үр нөлөөний тухай мэдээлэл
- d) Нөөцийн хангалттай байдал
- e) Эрсдэл болон боломжийг авч үзсэн арга хэмжээний үр нөлөө
- f) Сайжруулах боломжууд

#### **9.3.3 Удирдлагын дүн шинжилгээний гаралтууд**

Удирдлагын дүн шинжилгээний гаралтад дараах асуудал бүхий удирдлагын зөвлөлийн шийдвэрүүд болон арга хэмжээ хамаарна. Үүнд:

- a) Сайжруулах боломжууд
- b) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоонд оруулах аливаа өөрчлөлтийн хэрэгцээ
- c) Нөөцийн хэрэгцээ / санхүү, хүний нөөц, бусад/

Төв удирдлагын дүн шинжилгээг нотлох баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Удирдлагын дүн шинжилгээний шийдвэр нь төвийн алба, тасгуудын дараа жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж гүйцэтгэл нь дараагийн удирдлагын дүн шинжилгээгээр хэлэлцэгдэж байна.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Удирдлагын дүн шинжилгээний шийдвэр

## 10. Сайжруулалт

### 10.1 Ерөнхий зүйл

ЦССҮТ сайжруулах боломжуудыг тодорхойлох болон сонгох ба хэрэглэгчийн шаардлагыг хангах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ. Дараах арга хэмжээ хамаарна. Үүнд:

- а) Шаардлагыг хангах ирээдүйн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхээр бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах,
- б) Тааламжгүй үр дүнг залруулах, сэргийлэх буюу бууруулах,
- в) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны гүйцэтгэл болон үр нөлөөг сайжруулах

Сайжруулалтад залруулга, залруулах арга хэмжээ, байнгын сайжруулалт, огцом өөрчлөлтүүд, шинэчлэл болон дахин зохион байгуулалт хамаарна.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Үйлчүүлэгч болон эмч, ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан

### 10.2 Үл тохирол ба залруулах арга хэмжээ

10.2.1 Хэрэглэгчийн гомдол, саналыг оролцуулан үл тохирол, тохиолдол, аюул, эрсдэл илрэх үед ЦССҮТ нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- а) Үл тохирол, эрсдэл, тохиолдлын эсрэг доорх арга хэмжээний аль тохирохыг авна:
  1. Хянаж, залруулах арга хэмжээ авах,
  2. Үр дагаврыг арилгах
- б) Мөн:
  1. Үл тохирол, тохиолдол, эрсдэлд дүн шинжилгээ хийх, шинжлэх
  2. Үл тохирол, тохиолдол, эрсдлийн шалтгааныг тодорхойлох,
  3. Ижил төстэй үл тохирлууд байгаа, эсвэл тохиолдож болохыг тодорхойлох замаар үл тохирол хаа нэгтээ илрэх, дахин илрэхээс сэргийлэх зорилгоор түүний шалтгааныг арилгах арга хэмжээний хэрэгцээг үнэлэх,
- в) Шаардлагатай аливаа арга хэмжээг авах,
- д) Аливаа залруулах арга хэмжээний үр нөлөөнд дүн шинжилгээ хийх,
- е) Шаардлагатай гэж үзвэл, төлөвлөлтийн явцад тодорхойлсон эрсдэл, боломжуудыг шинэчлэх,
- ф) Шаардлагатай гэж үзвэл, чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоонд өөрчлөлт оруулах.

Залруулах арга хэмжээ нь илэрсэн үл тохирол, тохиолдол, эрдлийн үр дагаварт тохирсон байна.



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын  
12-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

Үл тохирол, тохиолдол, эрдлийг илрүүлэх, бүртгэх, шалтгааныг тодорхойлж, засч сэргийлэх журмыг мөрдөж ажиллана.

Төвийн алба, тасаг бүр, эмч, мэргэжилтэн ажилтан бүр үйл ажиллагааны явцад илэрсэн үл тохирол, тохиолдол, эрсдлийг илрүүлэх, бүртгэх, холбогдох эмч, эрхлэгч, удирдлагад мэдээлэх, шалтгааныг тодорхойлох, засч, сэргийлэх ажилд оролцох үүрэг хариуцлага хүлээнэ.

Алба, тасгийн эрхлэгч үйл ажиллагаанд тохиолдол, эрсдэл, үл тохирол үүсгэхгүй байх зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, удирдлагын дэмжлэг авах, тохиолдол, эрсдэл, үл тохирол илэрсэн үед зөв шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх удирдлагад мэдээлэх, засч, сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах, үүрэг хариуцлага хүлээнэ.

**10.2.2** ЦССҮТ нь баримтжуулсан мэдээллийг:

- а) Тохиолдол, эрсдэл, үл тохирлын мөн чанар, түүний дагуу авсан арга хэмжээнүүд,
- б) Аливаа залруулах арга хэмжээний үр дүнг нотлох зорилгоор хөтөлж, хадгална.

**10.3 Байнгын сайжруулалт**

ЦССҮТ нь нэгдсэн менежментийн тогтолцооны зохимж, тохиромж, үр нөлөөг үргэлж сайжруулна.

Төв нь байнгын сайжруулалтын хэсэг гэж авч үзэх хэрэгцээ болон боломжуудыг тодорхойлохын тулд дүн шинжилгээ, үнэлгээний үр дүн ба удирдлагын дүн шинжилгээний гаралтыг судална.

Төвийн алба, тасгууд үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийсэн ажлуудыг бүртгэн баримтжуулж, сайн туршлага, ололт, амжилтын сан үүсгэн бусдад сурталчилж, түгээн дэлгэрүүлнэ.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- ЦССҮТ-ийн гол үйл ажиллагаа, шинэлэг зүйлс

ТӨГСӨВ.